

СОЁМБО

БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТӨВ ХЭВЛЭЛ

2020.04.29 №17 (10694)

Үнэ 500 төгрөг

Дугаар эрхэлсэн дэслэгч Ц.ЭНХ-ОРГИЛ

САЙД Н.ЭНХБОЛД ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ХУУРАЙ ЗАМЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛД АЖИЛЛАВ



Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, Батланхамгаалахын сайд Н.Энхболд Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалд ажилласан юм. Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч, бригадын генерал Б.Амгаланбаатар орон нутагт шилжин байрласнаас хойших тус командлалын өдөр тутмын үйл ажиллагаа, цэргийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлж буй байдал, бие бүрэлдэхүүний ажиллах нөхцөл, бололцоог хэрхэн сайжруулж байгаа талаар мэдээлэл өгөв. Үүний дараа архив, хүний нөөц, баримт бичгүүдийн хадгалалт, хамгаалалт, нэгтгэл, ангиудтай сургалт, дадлагыг онлайнаар шууд явуулж байгаа байдалтай танилцсан юм. Мөн алба хаагчдын ажиллах орчин буюу сургалт, хурал, интернэт, бялдаржуулахын танхимууд, алдрын тасалгаа, номын сан, эмнэлгийн байрын тохижилт, үйлчилгээтэй танилцсан. Батлан хамгаалахын

сайд Н.Энхболд “Хуурай замын цэргийн командлал нь Зэвсэгт хүчиндээ төдийгүй төрийн бүх байгууллагад жишиг болохуйц хөгжсөн байна. Нэгтгэл, ангиудтайгаа онлайнаар сургалт, дадлагыг тогтмол явуулж, бэлэн байдал, бэлтгэлжилтийн бүх түвшинд онцгой анхаарч байгаа нь олзуурхуштай. Үүний сацуу алба хаагчид руугаа чиглэсэн олон арга хэмжээг хэрэгжүүлж байгаа нь маш сайн. Бялдаржуулах танхим, эмнэлэг, зоогийн газар нь бэлэн байна. Цаашид улам төгөлдөржүүлэхэд нь БХЯ-наас анхаарч ажиллана” гэсэн юм.

Батлан хамгаалахын сайдыг дагалдаж Батлан хамгаалахын сайдын зөвлөх Д.Бүрэнтогтох, БХЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, хурандаа Х.Батсайхан, ЗХЖШ-ын Ар талын газрын дарга, бригадын генерал М.Эрдэнэдалай, Төв аймгийн Засаг дарга Ж.Батжаргал нар ажиллалаа.

МОНГОЛ УЛСАД ГЕНЕРАЛ ЦОЛ БИЙ БОЛСНЫ 76 ЖИЛИЙН ОЙД

Ц.Тогоо: “УАЗ-469”-Д ЭЛСТЭЙ ШУУДАЙГААР ХАМГААЛАЛТ МАЯГИЙН ЮМ ХИЙГЭЭД ХАЛУУН ЦЭГ РҮҮ ЦЭРГЭЭ ИЛГЭЭХДЭЭ ӨРӨВДӨЖ Л СУУСАН



Зочинтойгоо ярилцаж суухдаа “Цэргийнхэн дэндүү залуугаараа тэтгэвэрт гарах юм. Тэтгэвэрт гарсныхаа дараа л энэ хүн өөрийгөө шинээр нээж, олон улсад үнэлэгдэхүйц алдрыг Монголын Зэвсэгт хүчинд авчирч дээ” хэмээн бодов. Тэр бээр тэтгэвэрт гарсныхаа дараа цэрэг, армидаа эргэн ирж, ид хаваа гайхуулсан бадам амжилт олныг гаргаж, генерал хэмээх эрхэм цолыг хүртжээ. Ингээд Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх, Монгол цэргийн нэгдсэн холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга, бэлтгэл дэслэгч генерал Ц.Тогоотой ярилцсанаа тоймлон хүргэе.

Энэхүү ярилцлагыг IV, V нүүрээс уншина уу

30 АЙЛЫН АЛБАН ТУШААЛЫН ОРОН СУУЦ АШИГЛАЛТАД ОРЛОО

Зэвсэгт хүчин, тэр дундаа Хуурай замын цэргийн командлалд 2020 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр нэгэн баярт үйл явдал тохиов. БХЯ, ЗХЖШ-ын дэмжлэгтэйгээр Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлал алба хаагчдынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд албан тушаалын 30 айлын орон сууцны Төв аймгийн Зуунмод хотноо барилдсныг энэ өдөр ашиглалтад хүлээн авсан юм. Энэхүү арга хэмжээнд Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Батлан хамгаалахын сайдын зөвлөх Д.Бүрэнтогтох, БХЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, хурандаа Х.Батсайхан, ЗХЖШ-ын Ар талын газрын дарга, бригадын генерал М.Эрдэнэдалай, Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч, бригадын генерал Б.Амгаланбаатар, Төв аймгийн Засаг дарга Ж.Батжаргал, барилгын ажлыг гүйцэтгэгч “Бутозм” ХХК-ийн захирал Б.Сүхболд тэргүүтэй албаны хүмүүс оролцож, ёслолын тууз хайчиллаа.

Батлан хамгаалахын сайд Н.Энхболд энэ үеэр хэлсэн үгэндээ “Шинэхэн байраа хүлээн авч байгаа Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалын бие бүрэлдэхүүнд тусгайлан баяр хүргэе. Командлал бие даан үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш бие бүрэлдэхүүний ажиллах, амьдрах орчин, нөхцөл нь маш их сайжирч байгаад сайдын хувьд баяртай байна. Ер нь алба хаагчдынхаа нийгмийн хамгааллыг сайжруулна гэдэг нь



цаад утгаараа эх орныхоо төлөө үүргээ сайн биелүүлэхэд чухал хөшүүрэг болдог. Болдогсон бол бүх цэргийн алба хаагчдадаа орон сууц барьж өгөх юм сан. Даанч тийм боломж байхгүй. Гэхдээ аль болох нийгмийн хамгааллыг нь дээшлүүлэх бодлогыг баримтлан ажиллаж байна” гэсэн юм.

Үүний дараа хүндэт зочид байрныхаа түлхүүрийг гардан авсан зарим алба хаагчийнхаар зочилсон бөгөөд хамгийн эхний айл нь Хуурай замын цэргийн командлалын Санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, хошууч Д.Дагвацэрэнгийнх байлаа. Тэрээр эхнэр, дөрвөн хүүхдийн хамт амьдардаг. Эхнэр нь Зэвсэгт хүчний 011 дүгээр ангид алба хаадаг цэргийн

бүсгүй аж.

Хошууч Д.Дагвацэрэн “БХЯ, ЗХЖШ, Хуурай замын цэргийн командлалын удирдлагад олон айлын нийгмийн асуудлыг шийдвэрлэж өгсөнд гэр бүлийнхээ нэрийн өмнөөс баярлалаа гэж хэлэе. Эхнэр бид хоёр үр хүүхдүүддээ санаа зовохгүйгээр үүргээ гүйцэтгэх болсондоо баяртай байна” гэв. Энэ үеэр Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч, бригадын генерал Б.Амгаланбаатар энэхүү албан тушаалын орон сууцанд өөрийн гэсэн байргүй, түрээсийн болон аав, ээжийндээ амьдардаг, олон хүүхэдтэй алба хаагчдаа хамруулсан тухай онцолсон юм.

(Үргэлжлэл нь II нүүрт)

ЭМЧ НАР СУРГАЛТАД ХАМРАГДАВ

Цаг үеийн байдалтай холбоотойгоор Улсын Онцгой комиссын шуурхай штабаас зөвшөөрөл авч, Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн ажлын албанаас Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагын 60 гаруй эмчийг хамруулсан сургалт, дадлагыг зохион байгууллаа.

Сургалтаар эмч нарт коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, халдварын тохиолдол илэрсэн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ, халдвар хамгааллын өмсгөл хэрэглэх заавар зэрэг сэдвээр мэдлэг

халдвараас урьдчилан сэргийлэх талаар Эрүүл мэндийн сайдын ирүүлсэн зөвлөмжүүдийн дагуу ЗХЖШ-ын Ар талын газрын Эрүүл мэндийн хангалтын хэлтсээс албан бичгийг тухай бүрд нь боловсруулан Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагуудад хүргүүлэн хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна. Мөн Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажилд хөдөлгөөнт эмнэлгийн бүлгийг томилгоожуулан үзлэг, ариутгал хийх цэгийг Дорноговь аймгийн Зүүнбаян баг, Өмнөговь аймгийн



олгосон бөгөөд дадлагажуулах арга хэмжээг давхар зохион байгуулсан юм. Мөн 2020 оны цэрэг халах, татах үед коронавирусийн халдвараас сэргийлэх зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээний зааврыг боловсруулан ЗХЖШ-ын Ар талын газрын даргын албан бичгийг Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын эмнэлгийн алба, Эрүүл мэндийн төвд хүргүүлжээ. Түүнчлэн коронавирусийн

Манлай сумын нутаг дэвсгэрт дэлгэн байгуулж, иргэдэд эрүүл мэндийн үзлэг, авто техникт ариутгал, халдваргүйтгэлийг хийж байгаа юм. Тус хэлтсээс коронавирусийн халдварын үед хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх зорилгоор ариутгал, халдваргүйтгэлийн бодис, халдвар хамгааллын материал, хэрэгслийн тодорхой нөөцийг бүрдүүлээд байгаа ажээ.

С.Баасанхүү: ҮЕ ҮЕИЙН ГЕНЕРАЛУУД УЛС ОРНЫ ХӨГЖЛИЙН БҮХ ШАТАНД МАНЛАЙЛЖ ОРОЛЦСОН

Монгол Улсад генерал цол бий болсны 76 жилийн ой тохиож байна. Үүнтэй холбогдуулан “Монгол генерал төв”-ийн тэргүүн, доктор, профессор, бэлтгэл хошууч генерал С.БААСАНХҮҮТЭЙ ярилцлаа.

Жил бүрийн 4 дүгээр сарын 28-ны өдрийг “Монгол генералын өдөр” болгон тэмдэглэсээр ирсэн. Энэ өдрийн гол онцлог юу вэ?

–Энэ өдөр амьд түүх болсон ахмад буурлууддаа хүндэтгэл үзүүлж, ажил, амьдралынх нь туршлага, туулж өнгөрүүлсэн замналыг нь залуу, хойч үеийнхээ оюун санаанд бага ч атугай шингээж гэж зорьдог. Үүний тулд жил бүр олон арга хэмжээг зохион байгуулдаг уламжлалтай. Тухайлбал, хэвлэл мэдээллийн хэрэгслээр ахмад генералууд маань хүнд цаг үеэс өнөөдрийн нийгэмд хэрхэн шилжсэн, цэргийн дарга ямар байх ёстой гэхчлэн хууч дэлгэсэн сайхан ярилцлагууд өгөх, төвлөрсөн арга хэмжээ, уулзалтууд буюу оюутан залуус, томоохон албан байгууллагуудад эх оронч үзлийн талаар яриа, таниулга хийх гээд нийгэмд хандсан олон ажил, арга хэмжээг зохион байгуулдаг юм. Энэ жил цаг үеийн нөхцөл байдлаас хамаараад төвлөрсөн уулзалт, хүндэтгэлийн арга хэмжээ, цэрэг-эх оронч яриа, таниулгыг хийх боломжгүй болсон.

Монгол Улсад хэдэн генерал байдаг вэ?

–Одоогоос 76 жилийн өмнө буюу 1944 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр БНМАУ-ын Ардын Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор цэргийн гарамгай 11 зүтгэлтэнд генерал хэмээх цэргийн дээд цол олгосон түүхтэй. Тэр цагаас хойш 185 цэргийн зүтгэлтэн энэхүү эрхэм цолыг хүртсэний 91 нь энх тунх байна. Үүнээс 27 нь төрийн цэргийн болон үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагад үүргээ гүйцэтгээд ажиллаж байна. Генерал цолтнуудын дотор маршал нэг, армийн генерал нэг, хурандаа генерал найм, дэслэгч генерал 20, хошууч генерал 110, бригадын генерал 41 байна. Үүнээс БНМАУ-ын баатар цолтон зургаа, Хөдөлмөрийн баатар гурав, дайн, байлдаанд оролцсон 34, төрийн өндөр албан тушаалыг хашсан 15, сансрын нисгэгч нэг, эрдмийн зэрэг цолтой 38, энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн болон олон улсын байгууллагад ажилласан 10 бий. Дипломат албанд ажилласан нь ч бас олон. Эдгээр тоо баримт нь Монголын генералууд зөвхөн батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах хэрэгт төдийгүй улс орныхоо хөгжлийн бүхий л үе шатанд манлайлан оролцож ирснийг илтгэх учиртай. Өнөөдөр хамгийн өндөр настай нь хурандаа генерал С.Лувсангомбо. Өдгөө 96 настай, энх тунх байгаа хурандаа генерал С.Лувсангомбо гуйд Улаанбаатар хотын захиргаанаас



орон сууц өгсөн сайхан мэдээ дуулдана лээ. Өмнөөс нь баярлаж л суулаа.

“Монгол генерал төв”-ийг байгуулах болсон түүхээс хуучлахагуй юу?

–1999 онд олон генерал нэг дор цугласан арга хэмжээ болсон юм. Хурандаа генерал Ж.Авхиа, Б.Дэжид, дэслэгч генерал Д.Ёндондүйчир, Б.Цэдэн-Иш, Ш.Арвай, Ж.Жамъян гээд барааг нь хараад л сүрддэг мундгууд цуглалаа. Бараг 70 гаруй хүн ирсэн байх. Өмнө нь тийм арга хэмжээ төдийлөн болж байгаагүй учраас их л идэвхтэй цугласан юм даг. Тэгсэн домгууд маань босож ирээд “Баасанхүү, нөхөр минь чи нэг юм бод. Бидний хэдэн генералууд цаашдаа тогтмол уулзмаар байна. Нэгнээ хараад сэтгэл их сөргэлээ. Залуу хүү та энэ ажлыг хий” гэж даатгасан. Тэр үед хамгийн сүүлд цол авсан шинэ цэрэг нь би байж таарсан л даа. Ингэж л би дарга нарынхаа тушаалаар хөөцөлдөж гүйсээр “Монгол генерал төв”-өө байгуулж, гэрчилгээ, тамга, тэмдгийг нь авсан юм. Үүнээс хойш 21 дэх жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна. Бид нэгдүгээрт, ахмад үеийнхээ түүх, уламжлал, замнал, гавьяат үйлсийг мартагнуулахгүй авч үлдэж, дараагийн хүмүүстээ өвлүүлж өгөх зорилготой. Үүний тулд хүүхэд багачууд, оюутан залуус, албан байгууллагуудад эх оронч үзэл, хүмүүжлийн талаар ярилцлага, лекцийг тогтмол хийдэг. Мөн жилд дор хаяж таван генерал ном бүтээж гаргаж байна. Энэ нь өөрийн мэдлэг, туршлагаа хуваалцах, үндсэн байгууллагууддаа мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байгаа юм. Хоёрдугаарт, генералууд маань айхтар сүрхий цол зүүсэн хэдий ч хүн шүү дээ. Алдаж онох, гуниж гутрахад нь тусалж, дэмжихийн төлөө явдаг. Гуравдугаарт, ижил төсөөтэй байгууллагуудтай хамтарч, үндсэн байгууллагууддаа дэм болох чиглэлээр ажилладаг. Үндсэн байгууллагад БХЯ, ЗХЖШ, ХХЕГ, ТЕГ, ОБЕГ, ЦЕГ, ШШГЕГ, ИНЕГ гэсэн найман байгууллага хамаарна.

30 АЙЛЫН АЛБАН ТУШААЛЫН ОРОН СУУЦ АШИГЛАЛТАД ОРЛОО

(Түрүүч нь I нүүрт)

Дараагийн айл нь Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалын Захиргааны удирдлагын хэлтсийн хэрэг хөтлөгч, дэд ахлагч Б.Нандин-Эрдэнийх.

Түүний нөхөр Э.Дүүрэнжаргал өдгөө БНСУ-д ажиллаж байгаа бөгөөд тэд сургуулийн насны гурван хүүхэдтэйгээ аав, ээжийндээ амьдардаг байсан юм. Зээ охиноо албан тушаалын орон сууцтай болсон баярт мэдээг сонссон өвөө Н.Буянтгогтох, эмээ Д.Цагаанхүү нар гэрт нь хүрэлцэн ирсэн байв. Н.Буянтгогтох гуай Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч, бригадын генерал Б.Амгаланбаатар нарт хандаж “Ийм сайхан байрандаа миний охины гэр бүлийг оруулж өгсөнд баярлалаа. Та бүхний ажил үйлс үргэлж өөдөө бай” гэж ерөөсөн. Тэрээр 1960-аад онд Барилгын цэргийн ангид гурван жилийн алба хааж байхдаа эзэмшсэн мэргэжлээрээ буюу мужаанаар улсад 36 жил ажиллажээ. Цэргийн албаар үргэлж бахархаж явдгаа ч илэрхийлэв. Зочдыг гарах үеэр Э.Дүүрэнжаргал, Б.Нандин-Эрдэнэ нарын том хүү Д.Анхбаяр “Цэргийн ах, эгч нартаа баярлалаа. Биднийг маш гоё байртай болгосонд талархлаа” хэмээсэн нь олон хүний сэтгэлийг хөдөлгөж чадсан юм.

Төгсгөлд нь онцлох айл бол тус командлалын Артиллерийн дарга, дэд хурандаа С.Ууганбаярынх. Тэднийх ам бүл долуулаа бөгөөд тэдний хүүхдүүдийн дийлэнх нь цэрэг, цагдаагийн байгууллагад ажилладаг аж. Гэр бүлийн хүн нь ч ялгаагүй мөрдөстэй цэргийн бүсгүй ажээ. Дэд хурандаа С.Ууганбаяр “Үнэхээр их баяртай байна. Миний бие Зэвсэгт хүчинд 26 дахь жилдээ алба хааж байна. Зэвсэгт хүчний 256, 120, 084 дүгээр ангид алба хааж байгаад гурван жилийн өмнөөс уг албан тушаалд томилогдон ажиллаж байна. Офицер, ахлагч нарын хүүхдүүд цэрэг, армидаа элэгтэй болж өсөж торнидог жишгээр долоодугаар ангийн бага охиноос маань бусад нь Зэвсэгт хүчний 084, 310, 340 дүгээр анги болон цагдаагийн байгууллагад алба хааж байна. Гэртээ нэг тасаг командлаад амьдарч байна



гэсэн үг. Өнөөдөр ийм сайхан байртай болсондоо маш их баяртай байна. БХЯ, ЗХЖШ, удирдлага, хамт олондоо хань, үр хүүхдүүдийнхээ өмнөөс баярласнаа илэрхийлэв. Одоо ажлын төлөө зүтгэхээс өөр зүйлгүй” гэв.

Үүний дараа Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч, бригадын генерал Б.АМГАЛАНБААТАРААС сэтгэгдлийг нь сонссон юм.

–УИХ-аар 2016 онд Батлан хамгаалахын багц хуулиуд шинэчлэгдэн батлагдаж, Зэвсэгт хүчний Хуурай замын цэрэг нь бие даасан төрөл цэрэг болсныг та бүхэн мэднэ. Энэ цагаас хойш Хуурай замын цэргийн бие даасан үйл ажиллагааг хангах зорилгоор БХЯ, ЗХЖШ-аас шат дараатай арга хэмжээг тасралтгүй хэрэгжүүлж, зохих үр дүнд ч хүрлээ. 2017 оны 4 дүгээр сард манай командлал Байлдааны тугаа хүлээн авч байсан бол 2019 оны 9 дүгээр сард өөрийн гэсэн байртай болж, өдгөө офицер, ахлагч нарын албан тушаалын 30 айлын орон сууцыг ашиглалтад хүлээн авч байна. Хуурай замын цэргийн командлалын бие даасан байдлыг бүрэн хангах хүрээнд удирдлага, бие бүрэлдэхүүний нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн БХЯ, ЗХЖШ, Төв аймгийн удирдлагад талархлаа илэрхийлэв. Энэхүү байрыг барихад орон нутгаас дэд бүтцийг нь бүрэн шийдэж өгснийг дурдах ёстой. Цаашдаа алба хаагчдын нийгмийн хамгааллыг шийдвэрлэх ажил үргэлжилнэ.

Ахлах дэслэгч Д.БОЛОРМАА

ЧУХАЛ ШААРДЛАГАТАЙ ЖУРМУУД ШИНЭЧЛЭН БАТЛАГДЛАА

Дайчилгааны тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабаас 2019 онд хэд хэдэн журмыг боловсруулж шинэчлэн батлуулсан юм. Үүнтэй холбогдуулан БХЯ-ны СБТГ-ын Орон нутгийн хамгаалалт, улсын дайчилгааны хэлтсийн ахлах мэргэжилтэн, дэд хурандаа С.РАГЧААДОРЖООС тодруулга авлаа.

Нийт хэдэн журам шинэчлэн батлагдсан бэ?

–Улсын Их Хурлаар 2018 онд “Дайчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хууль батлагдсанаар энэхүү хуулийн өөрчлөлтөд нийцүүлэн дайчилгааны эрх зүйн харилцааг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага бий болсон. Иймд Батлан хамгаалахын сайдын “Хуулийн хэрэгжилтийг хангах тухай” 2018 оны тушаалд заасны дагуу дайчилгааны харилцааг зохицуулж буй нийт 20 орчим эрх зүйн баримт бичгийг 2018-2021 онд шинээр болон шинэчлэн боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах ажил хийгдэж байна. Энэ ажлын хүрээнд 2018 онд нэг, 2019 онд есөн журам шинэчлэн батлагдсан. Тодруулбал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны зарлигаар “Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, тэдгээрийг дайчлах журам”, “Засгийн газрын 2018 оны тогтоолоор “Аюулгүй байдал, батлан хамгаалах асуудлаар төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, бие бүрэлдэхүүнтэй сургалт, дадлага явуулах журам”, Засгийн газрын 2019 оны тогтоолоор “Дайчилгааны зарлан мэдээлэл явуулах журам”, “Дайчилгааны нөөцийг бүрдүүлэх журам”, “Хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн өмчийг дайчилсан тохиолдолд нөхөх олговор төлөх журам”, “Дайчилгаатай сургууль явуулах журам”, “Техник, хэрэгслийг дайчилгаатай сургуульд татан оролцуулсны хөлсийг төлөх журам”, “Хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжээс дайчилсан санхүүгийн нөөцийг буцаан төлөх журам”, Засгийн газрын 2019 оны тогтоолоор “Иргэн, цэргийн бэлтгэл үүрэгтнийг орон нутгийн хамгаалалтын болон цэргийн сургалт, цэргийн дайчилгаатай сургуульд оролцох хугацааны цалин хөлсний дундаж хэмжээг тогтоох, түүнийг олгох журам”, Батлан хамгаалахын сайдын 2019 оны тушаалаар “Цэргийн бэлтгэл албаны сургалтын журам” зэрэг 10 журмыг шинээр болон шинэчлэн боловсруулж, хуульд заасан эрх бүхий байгууллага, албан тушаалтнаар батлуулаад байна

Журмуудыг шинэчлэх хэрэгцээ, шаардлага юу байв?

–Шинэчлэн батлагдсан журмуудын тухай хууль батлагдан гарсны дараа дээрх журмууд анх боловсруулагдан 1999-2003 онд батлагдсан байдаг. 2015 оноос эхэлсэн Батлан хамгаалах салбарын эрх зүйн шинэчлэл, улс орны нийгэм, эдийн засагт гарсан өөрчлөлтүүд, хүн амын өсөлт, бүтэц, чанарын өөрчлөлт, Зэвсэгт хүчний хөгжлийн түвшин зэргээс шалтгаалан дээрх журмуудыг батлагдан гарсан хууль, тогтоомжуудад нийцүүлэх, давхардал, хийдлийг арилгах, нийгэм, эдийн засгийн өөрчлөлтөд нийцүүлэх зэрэг хэрэгцээ, шаардлага тулгарч байсан бөгөөд эдгээр өөрчлөлт нь цаг үеэ дагасан шинэчлэлүүд гэж ойлгож болно.

Шинээр батлагдсан журмууд нь хууль, эрх зүйн ямар зохицуулалтыг нарийвчлан тусгасан талаар тодруулахгүй юу?

–Шинэчлэн батлагдсан журмууд нь батлан хамгаалахын багц хуулиудад тусгагдсан эрх зүйн харилцааг нарийвчлан тодорхойлох, эрх зүйн зохицуулалтын давхардал, хийдлийг арилгах, шаардлагагүй болсон зарим зүйл, заалтыг хасах, нэр томъёоны шинэчлэлийг тусгасан зэрэг онцлогтой. Тухайлбал, “Дайчилгааны зарлан мэдээлэл явуулах журам”-ын тухайд, дайчилгааны зарлан мэдээллийн тогтолцоо нь төрийн захиргааны, төрийн цэргийн болон орон нутгийн зарлан мэдээллийн тогтолцооноос бүрдэхээр нарийвчлан тодорхойлсноос гадна дайчилгааны орон нутгийн зарлан мэдээллийн тогтолцоог орон нутгийн хамгаалалтын зарлан мэдээлэлд ашиглахаар, зарлан мэдээлэл явуулах бэлтгэлийг хэрхэн хангах, зарлан мэдээллийг зохион байгуулж явуулах үйл ажиллагааны уялдаа холбоог нарийвчлан журамласан онцлогтой. Мөн “Дайчилгаатай сургууль явуулах журам”-д зааснаар Засгийн газрын шийдвэрийн дагуу Зэвсэгт хүчний Жанжин штаб дайчилгаатай сургуулийг жил бүр зохион байгуулж, явуулах эрх зүйн үндсийг бүрдүүлжээ. Ингэснээр Зэвсэгт хүчний Жанжин штаб нь дайчилгаатай сургуулийн удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалтыг, Төрийн цэргийн командлал нь дайчилгаатай сургууль явуулах цэргийн нэгтгэл, ангийн бэлтгэлийг хангуулах ажлыг, Батлан хамгаалах яам сургууль явуулах шийдвэрийг Засгийн газраар



шийдвэрлүүлэх, сургуулийн явцад хяналт тавих үүргийг тус журамд тусгасан. Түүнээс гадна дайчилгаатай сургууль явуулах үйл ажиллагааг нарийвчлан журамласан юм. “Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, тэдгээрийг дайчлах журам”-аар дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг дайчлах ажлыг зохион байгуулах субъект, ажлын дарааллыг тодорхой болгож өгсөн бөгөөд гадаад улсад оршин суугаа цэргийн бэлтгэл үүрэгтнийг дайчлах ажлын зохион байгуулалтыг тусгай бүлэг болгон тусгаж өгсөн онцлогтой. Түүнээс гадна энэхүү журмыг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын асуудлыг журамласан. Мөн дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний насны хязгаарыг “Цэргийн албаны тухай” хуулийн 32 дугаар зүйлд, дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг дайчлах ажлыг зохион байгуулах талаарх Засгийн газар, Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрх, Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, бусад төрийн захиргааны төв байгууллага болон нутгийн захиргааны байгууллагын үүргүүдийг Дайчилгааны тухай хуульд нарийвчлан заасан тул хууль, эрх зүйн давхардлыг арилгах үүднээс хуучин журмын зарим зүйл, заалтыг хассан зэргийг дурдаж болох юм.

Бусад журмын тухайд ...

–“Дайчилгааны нөөцийг бүрдүүлэх журам”-ын хувьд, дайчилгаа зарласан үед дайчлан татахаар төлөвлөгөөнд тусгагдсан байгууллага, аж ахуйн нэгж, иргэний өмчлөлд байгаа зэвсэг, техник хэрэгсэл, эд хөрөнгийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр бүртгэж, дайчилгааны нөөцийг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулсан. Дайчилгааны нөөцийн нэр төрөл, тоо хэмжээ, байршил, нөөцийг бүрдүүлэх болон нөөцтэй байх аж ахуйн нэгж, байгууллагыг Цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллага тодорхойлж, уг саналыг болон шаардагдах төсвийн асуудлыг Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Засгийн газарт танилцуулан шийдвэрлүүлэх зохицуулалтыг хийж өгсөн. Түүнчлэн, Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дайчилгааны даалгавраар тогтоосон дайчилгааны нөөцийн бүрдүүлэлт, хадгалалт, арчлан хамгаалалтад жил бүр үзлэг, шалгалт явуулж байх бөгөөд үзлэг, шалгалт явуулах бүрэлдэхүүн, хугацааг Засгийн газар тогтоох зохицуулалтыг хийсэн.

“Хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн өмчийг дайчилсан тохиолдолд нөхөх олговор төлөх журам”-д хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн дайчилгасан өмчийг буцаан төлөх хэмжээг тогтоох хугацаа болон нөхөх олговрыг төлөх хугацааг тодорхой тусгасан бөгөөд нөхөх олговор хүү, алданги тооцохгүй байхаар, нөхөх олговрыг биет хэлбэрээр буцаан төлөхдөө зохих хуулийн дагуу элэгдлийг тооцон олгохоор тусгалаа. Мөн “Хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжээс дайчилсан санхүүгийн нөөцийг буцаан төлөх журам”-д дайчилж болох санхүүгийн нөөцийг бэлэн болон бэлэн бус мөнгө, мөнгө, түүнтэй адилтгах хэрэгсэл гэсэн гурван хэсэгт ангилан тэдгээрт хамаарах нөөцүүдийг тодорхой зааж өгсөн. Мөн Улсын Их Хурлын шийдвэрийг үндэслэн хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжээс дайчилсан санхүүгийн нөөцийг буцаан төлөх хугацааг нарийвчлан тодорхойлсон.

Шинэчлэн батлагдсан эдгээр журмын ач холбогдлын тухайд ...

–Товчхондоо эдгээр журмууд батлагдсанаар Дайчилгааны тухай хуулийн хэрэгжилт хангагдах, дайчилгааны зарлан мэдээлэл явуулах, нөөц бүрдүүлэх, нөхөн олговор төлөх болон дайчилгаатай сургуулийг явуулах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт боловсронгуй болсны зэрэгцээ дайчилгааны үед байгууллага, аж ахуйн нэгж, иргэд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх асуудал тодорхой болж байгаа юм.

ДУГААРЫН СУРВАЛЖИЛГА

ТЭДНИЙ ӨМНӨӨС ХИЙСЭН АЖИЛ НЬ “ЯРЬДАГ”

Баянзүрх дүүрэг нь засаг захиргааны олон нэгжтэй, хүн ам олноор суурьшсан нийслэлдээ томоохонд тооцогддог дүүрэг юм. Түүх сөхвөөс, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1965 оны 79 дүгээр зарлигаар Улаанбаатар хотыг дөрвөн районд хувааж, Сэлбэ голоос зүүн тийш хэсгийг тэр үеийн Амгалангийн болон Сүхбаатарын хороо захиргаатай нийлүүлэн Найрамдлын районуы байгуулжээ. 1992 онд УИХ-ын тогтоолоор Найрамдлын районуы Баянзүрх дүүрэг гэж нэрлэжээ. Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Хил хамгаалах Ерөнхий газар, Цэргийн төв эмнэлэг, ҮБХИС, ДХИС, Зэвсэгт хүчин, Хилийн цэрэг, Онцгой байдал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын ангиуд байрлаж, үйл ажиллагаа явуулдаг нь тус дүүргийг цэргийн тодотголтой онцлог дүүрэг болгосон.

Тэр ч утгаараа Засаг даргын Тамгын газар нь эдгээр анги, байгууллагуудтай иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах чиглэлээр нягт хамтарч ажилласаар ирсэн гэдгийг хэлэх нь зүйн хэрэг биз ээ. Энэ бүхэн мэдээж Баянзүрх дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабын оролцоотойгоор явагддаг. “Өөдлөх айл үүднээсээ” гэдэгчлэн тус Цэргийн штабаар зочлоход өрөөний тохижилт, зохион байгуулалт нь өөрийн эрхгүй анхаарал татав.

Бас үүдэн хэсэгт суугаа иргэд гадуур нь зузаан гэгч хавтаслан гэдсэн “Соёмбо” сонины дугааруудыг гарчиглаж байх нь нүдэнд содон тусна. Ийм дүр зурагтай төдийлөн таарч байгаагүй тул сэтгэлд туйлын өөг санагдсан. Эндээс л Цэргийн штабын иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх ажил эхэлдэг гэмээр. Энгийн зүйл хүнд хүрдэг гэдэг шүү дээ. Сурвалжилгынхаа

бэлтгэл нөөцийн болон хорооны Засаг дарга нарын сургалтыг төлөвлөгөөний дагуу явуулдаг. Мөн “Орон нутгийн хамгаалалтын тухай” хууль батлагдсантай холбогдуулан хуулийн хэрэгжилтийг хангахад Цэргийн штабын хамт олон маань мэргэжил, арга зүй, ажлын идэвх, санаачилгатай ажиллаж байна.

Хорооны Засаг дарга нарын цэргийн хэргийн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн цэргийн сургалт бэлтгэлийг жил бүр зохион байгуулж байна. Хуримтлуулсан туршлагадаа үндэслээд жил бүрийн сургалтын төлөвлөгөөгөө шинэчлэн, төгөлдөржүүлэх талаар анхаарч ажилладаг. Сүүлийн жилүүдэд танхимын сургалтаас дадлага болон бие бялдрыг хөгжүүлэх чиглэлийг барьж ажиллах болсон. Мөн Цэргийн дүйцүүлэх алба хаагчдын цэргийн анхан шатны болон тусгай үүргийн бэлтгэл сургалтыг цаг хугацаанд нь дүүргийнхээ онцлог, давуу тал болох Зэвсэгт хүчний анги, байгууллагуудын материаллаг баазыг түшиглэн тогтмол явуулдгийг дурдах нь зүйн хэрэг” гэв.

Мөн дүүргийнхээ цэргийн насны залуусын эрүүл мэндийг сайжруулах талаар хийгдэж байгаа ажлуудыг танилцуулсан. Тодруулбал, жил бүрийн цэрэг татлагад эрүүл мэндээр тэнцээгүй иргэдийн судалгаанд үндэслэн асуудалд илүү бодитойгоор ханддаг. Үүнийг батлах зүйлсийг дор өгүүлвэ. Баянзүрх дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабаас цэргийн насны залуучуудыг эрүүлжүүлэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээг хүртээмжтэйгээр хүргэхээр хорооны Засаг дарга нар, өрхийн эмнэлгүүд, дүүргийн эрүүл мэндийн төвтэй хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор “Диспансерын хяналт-эмчлэн эрүүлжилт” сэдэвт цэргийн насны залуучуудын эрүүл мэндийг



Дэд хурандаа Т.АМАРТОГТОХ

“Хууль тогтоомж-Иргэн цэргийн харилцааны жил” болгон зарлаж, энэ зорилтын хүрээнд Баянзүрх дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штаб нэлээд ажил, үйлчилгээг төлөвлөн хэрэгжүүлж байгаа гэдгээ хэлэв.

Дэд хурандаа Т.Амартогтох энэ талаар тодруулахдаа, “Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабаас 2019 онд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааг маань шалгаж үнэлээд бүрэн хангалттай гэж дүгнэсэн. Нийслэл, дүүргийн Цэргийн штабын Ажил мэргэжлийн аваргаар тоо бүртгэлийн офицер, дэд хурандаа Э.Амарбат шалгарсан. Энэ нь бидний ажлын бас нэг үзүүлэлт боллоо.

Мөн иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх хүрээнд ч онцлох ажлууд хийгдэж, ахиц дэвшилд хүрсэн. Тус дүүрэгт байрладаг Зэвсэгт хүчний анги, байгууллагуудын өмнө тулгамдсан зарим асуудлыг шийдвэрлэхэд нь ЗДТГ болон Цэргийн штабаас дэмжлэг үзүүлсээр ирсэн. Тухайлбал, Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн соёл, амралтын өрөөг нь тохижуулах, спорт заалыг будаж сэргээн засварлах мөн 284 дүгээр ангийн штабын байрны дээврийн засварын ажилд шаардлагатай хөрөнгийг ЗДТГ-аас шийдвэрлэж өгсөн. Түүнчлэн Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн офицеруудын танхимын засварын ажил, Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн Соёлын төвийн засварын ажлыг хийж гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлсэн” гэв. Мөн түүний ярианд дурдагдаж амжаагүй Монгол Улсын Засгийн газрын 2018 оны хуралдаанаар “Түүхий нүүрсийг хориглох тухай” тогтоолоор батлагдсан, нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд уурын зуухаар галладаг Зэвсэгт хүчний 124, 084, 065, 015, 310 дугаар ангиудын болон Зэвсэгт хүчний Жанжин штабын алба хаагчдын 36 айлын орон сууцны барилгад техникийн нөхцөл болон шинээр зураг, төсөв боловсруулах ажлыг холбогдох байгууллагуудаар хийлгэн, төвлөрсөн дулааны хангамжид холбуулах ажлыг нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар шийдвэрлүүлэн шаардагдах төсвийг батлуулж, төвлөрсөн дулаанд холбосон зэрэг олон ажлыг нэрлэж болно. Ийнхүү Зэвсэгт хүчний анги, байгууллага, дүүргийн хороодтойгоо нягт хамтран ажилласнаар иргэн-цэргийн харилцаа сүүлийн жилүүдэд илүүтэй бэхжиж байгааг онцолж байлаа.

Тус Цэргийн штаб нь дүүргийн хэлтэс, нэгжүүдтэй хамтран ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад цэрэг-эх оронч үндэсний бахархалт үзлийг төлөвшүүлэх зорилгоор Монгол Улсын Зэвсэгт хүчин, анги, байгууллагын түүх, дайчин уламжлал, алдар гавьяа, үйл ажиллагааг сурталчлах ажил, “Монгол цэрэг-Дэлхийн цэрэг” нээлттэй хаалганы өдөрлөг, “Цэрэг-эх орон” сэдэвт зохион бичлэг, гар зургийн уралдаан, дүүргийн Засаг даргын нэрэмжит цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээнийг жил бүр зохион байгуулж байна. Мэдээж жил бүр шагналын сангаа өсгөж, сурагчдыг урамшуулах байдлаар дараа дараагийн уралдаан, тэмцээнүүдэд идэвхтэй хамрагдах сэдлийг нь өдөөж өгдөг гэдгийг хэлэх нь зүйн хэрэг.

Үргэлжлүүлэн бусад ажлаас онцолбол, “Орон нутгийн хамгаалалтын тухай” хуулийг хэрэгжүүлэхийн тулд Баянзүрх дүүргийн Засаг даргын захирал, ЗДТГ-ын даргын тушаалаар Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг байгуулж, ажил, үүргийн хуваарийг баталгаажуулсан. Үүний үр дүнд дүүргийн Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг нийслэлийн Засаг даргаар оны



Зүүн гар талаас: Өвөр эгнээнд, дэд хурандаа Ш.Бат-Өлзий, Т.Амартогтох, Э.Амарбат, арын эгнээнд ахлагч О.Эрдэнэдалай, дэд хурандаа Б.Уранчимэг, хошууч Л.Батзориг

өмнө батлуулж, одоо хэрэгжилтийг нь ханган ажиллаж байна.

Цэргийн штабын бие бүрэлдэхүүн хээрийн байрлалд үүрэг гүйцэтгэх боломжийг нэмэгдүүлэхээр хээрийн майхан, цахилгаан үүсгүүр, хээрийн гал зуух, эвхдэг ор, аяны хөнжил, аранз нэмж тодотгоход, “Геополитикийн хувьд хоёр их гүрний дунд оршдог манай улсын иргэд аливаа цагийн байдалд дасан зохицож үүрэг гүйцэтгэх чадвартай байх нь чухал. Үүний тулд “Орон нутгийн хамгаалалтын тухай”, “Дайчилгааны тухай” хуулиудын хэрэгжилтийг ханган дайчилгааны бэлтгэл нөөцийн сургалтыг чанаржуулж, томилгоот бие бүрэлдэхүүний мэдлэг, чадварыг дээшлүүлсээр тухайн орон нутгийн иргэд онц байдлын үед болон шаардлагатай тохиолдолд богино хугацаанд өндөр зохион байгуулалтад орж ажиллах боломж бүрдэх юм” гэх мэдээллийг ч хүргэсэн. 2019 онд хийгдсэн ажлуудаас онцлох нь энэ.

Харин 2020 онд Чөлөөлөх дайны ялалтын 75, Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штаб үүсч байгуулагдсаны 95 жилийн ой тохиож байгаагаараа онцлог.

самбар, “Цэрэг хүү” нэртэй шторк, Цэргийн штабын үйл ажиллагаатай холбогдолтой хавтсанд хөтлөгдөх баримт бичиг, товьёог, нугалбар, тараах материалыг нэг стандарт, загвар оруулж, төрийн үйлчилгээг иргэдэд үзүүлж байна.

Үүний зэрэгцээ Баянзүрх дүүргийн ЗДТГ-аас 2020 оныг “Залуучуудын хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан мөн л Цэргийн штабын хамт олон холбогдох зарим ажлуудыг хэрэгжүүлж байгаа аж. Ингэхдээ өмнөхөөсөө суралцах, туршлага хуримтлуулан улам төгөлдөржүүлж ажиллана гэв.

Дэлхий дахинд шинэ төрлийн коронавирусийн халдварт өвчин тархаж, цар тахлын хэмжээнд хүрч манай улсад өндөржүүлсэн бэлэн байдал зарлан, хорио цээрийн дэглэмийг тогтоогоод нэлээдгүй хугацаа өнгөрөөд байна. Энэ хугацаанд ЗДТГ-ын Цэргийн штабын хамт олон дүүргийн шуурхай штабт эргүүл, жижүүрээр гарч, иргэдэд өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар, зөвлөмж, зөвлөгөөг хүргэх ажилд гар бие оролцон тусгай үүргүүдийг гүйцэтгэн ажиллаж байгааг үнэлэх учиртай. Цаашид тус цэргийн штабын бие бүрэлдэхүүн цаг үеийн



эхэнд Баянзүрх дүүргийн ЗДТГ-ын дарга Б.Амартүвшинтэй ажлын ширээнийх нь ард ярилцлаа. Тэр бээр “Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний алба хаагчдынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэх болон тэдэнтэй хамтран ажиллах хүрээнд хийгдэж байгаа ажлууд сүүлийн жилүүдэд ихээхэн ахицтай байна. Цэргийн анги, байгууллагын тоо ч бусад дүүргээс харьцангуй олон. Одоо ажиллаж байгаа болон тэтгэврийн насны иргэдийн цөөнгүй хувь нь энэ салбарынхан. Энэ ч утгаараа иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх чиглэлд онцгой анхаарч ажилладаг. Цэргийнхэн, бэлтгэл,

дэмжих гурван сарын аяныг зохион байгуулсан. Аяны хүрээнд цэрэг татлагаас эрүүл мэндийн шалтгаанаар чөлөөлөгдсөн залуусыг хамруулснаас 25 хувийг нь хяналтад байлгаж эмчилсэн. ЗДТГ, Цэргийн штабын зүгээс цэргийн насны залууст эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүлжүүлэх талаар олон ажлыг төлөвлөн хийдэг ч зарим үед иргэдийн идэвх, оролцоо бас дутмаг байдгийг сануулсан. Цаашид цэргийн насны залуусыг аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамрагдахад уриалж, идэвхжүүлэх ажлыг далайцтай зохион байгуулахаар төлөвлөж байгаа гэдгээ онцолсон юм. Түүнчлэн ЗДТГ-ын дарга Б.Амартүвшингийн хэлснээр “МҮОНРТ”-ээр гарч байсан “Тусгай салаа” кино нь цэрэг-эх оронч үзлийг төлөвшүүлэх, Батлан хамгаалах, Зэвсэгт хүчнийг сурталчлахад жинтэй хувь нэмэр оруулсан гэв. Үнэхээр ч тус киног үзээд хугацаат цэргийн алба хаах хүсэлтэй залуусын идэвх, хандлага нэмэгдсэн нь үнэн юм.

Тэрээр “Батлан хамгаалах, Зэвсэгт хүчнээ сурталчилсан, иргэд рүүгээ чиглэсэн тодорхой төсөл, үйл ажиллагааг Батлан хамгаалах яам, ЗХЖШ, нийслэл, дүүргүүдийн Цэргийн штаб, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагууд хамтран хэрэгжүүлээсэй гэж хүсдэг. Гэхдээ энэ бол миний хувийн бодол шүү” гэв.

Үргэлжлүүлэн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, дэд хурандаа Т.Амартогтохтой уулзах үеэр Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабаас 2020 оны



Б.АМАРТҮВШИН

чөлөөнд байгаа ахмадуудаа хүндэтгэл үзүүлдэг “Андуудаа одонгоо зүүцгээ” ёслолын ажиллагаа нь 2010 оноос хойш жил бүр уламжлал болгон зохион байгуулагдаж ирсэн онцлох ажил.

ЗДТГ-ын зүгээс Батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах, цэргийн бүртгэл, цэрэг татлага, дайчилгааны



Хээрийн байрлалд үүрэг гүйцэтгэх боломж дээшилжээ



Цэрэг спортын “Дөл” тэмцээний үеэр

Тиймээс ойн хүрээнд тус цэргийн штабын хамт олон хөл хөдөлгөөн ихтэй, хөдөлмөр үйлс арвинтай байх нь дамжиггүй. Ер нь ч жилээс жилд тийм л дүр зураг ажиглагддаг. Үүнтэй ч маргах хүн үгүй биз. Тус хамт олон ч иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, сургалт, сурталчилгааны чиглэлээр олон ажлыг дотооддоо төлөвлөн, хэрэгжилтийг нь ханган ажиллаж байна. Мөн Нийслэлээс энэ жил “Нэг хот-нэг стандарт” хөтөлбөр, зорилгыг дэвшүүлсний

нөхцөл байдалтай холбогдуулан хүн нэг бүрийнхээ сахилга, зохион байгуулалтыг дээшлүүлэх зэргээр Улсын онцгой комисс болон Эрүүл мэндийн яамнаас гаргасан зөвлөмж, зөвлөгөөг даган биелүүлж уг халдварт өвчнөөс өөрийгөө болон нөхдийгөө хамгаалцгааа хэмээн уриалсан юм. Энэ мэтчилэн тэдний өмнөөс хийсэн ажил нь “ярьж”, чухамдаа бүтээлч, хөдөлмөрч хамт олон болохыг нотолж буй нь эргил

Дэслэгч Ц.ЭНХ-ОРГИЛ

Ц.Тогоо: “УАЗ-469”-д элстэй шуудайгаар хамгаалалт маягийн юм

(Түрүүч нь I нүүрт)

Монгол эрчүүд энэ жил овоонд гараагүй, чоно агнаж чадаагүй. Хийморь нь мөд сэргэхгүй гэсэн онигоо гарсан байна лээ. Таныхаар хийморь гэж юу вэ?

-1999 оны Цагаан сараар аавдаа очиж золгохоор гэр бүлээрээ нутаг руугаа явлаа. Шинийн гурванд нийслэл рүү буцаж явтал Төв аймгийн Лүн сумын цаахан талд хар зам дээр 13.40 цагийн орчим сүрэг чоно тааралдсан. Тэрүүхэндээ “Энэ чинь ямар учиртай чонон сүрэг гэгээн цагаан өдрөөр гэнэт гараад ирэв” гэж гайхсан. Тэгээд сэхээ авч жолооч Баяраатай хамт хэдэн чоно хөөгөөд нэгийг нь агнасан удаатай. Зарим хүн зориуд мордож, өдөр, шөнөгүй хайн, үргээж хөөгөөд ч чоно агнаж чадсангүй гэж ярьдаг. Тийм ховор тэнгэртэй амьтан өөрөө зам дээр гарч ирсэнд бэлгэшээдэг. Домог, бэлгэдэл зүйгээр ч чоно нь эр хүний хийморь сүлдтэй холбоотой гэдэг юм билээ. Нөгөө талаасаа хүнд аав, ээжийн буян, төрсөн нутаг усны хаялга, найз, нөхдийн ивээл, зөв амьдарсны үр шим ирдэг бололтой. Энэ бүгд нийлж хүний хийморь лундааг сэргээдэг. 2000 онд Батлан хамгаалах салбартаа эргэж ирсэн. Ирэх, ирэхдээ Батлан хамгаалахын дэд сайдаар томилогдсон. Тиймээс би ном уншуулан хийморио дуудаж, эсвэл хаа нэгтэйгээс зориуд эрж, хайх биш, хамгийн гол нь зөв явахад болно гэж боддог.

Яагаад эргэн ирсэн гэж ... Салбартаа нэг хэсэг орхисон гэсэн үг үү? Эсвэл ажлаасаа халагдсан ч юм уу?

-Цэргийн нэгтгэл, анги, сургуульд илүү ч үгүй, дутуу ч үгүй 25 жил ажиллаад тэтгэвэртээ гарсан. 1996 онд сонгууль болж, өнөөгийн улс төржилтийн эхлэл тавигдсан. Хаа сайгүй халаа, сэлгээ хийж, олон хүнийг ажил, албанаас нь чөлөөлсөн. Тэрхүү улс төржилтийн хоморгод өртөж, 1996 оны сүүлчээр ажлаа өгсөн юм. Уг нь цэргийн сургуулийг гайгүй төгссөн, ажил үүргээ нэр төртэй биелүүлсэн учраас халагдах шалтгаан байхгүй л гэж боддог байв. Эр бие, мэдлэг, оюун тэгширсэн 43 настайдаа ажилгүй болсон. Гэхдээ цэргийн хоёр, гурван шатны сургууль төгссөн, армийн анхан шатны нэгжээс нь эхлээд салаа, салбар, батальон, хороо, дивизид алба хашчихсан учраас гомдох зүйл алга гэж бодоод тэтгэвэртээ гарсан юм. Тэгсэн 1997 оны нэгдүгээр сарын сүүлчээр Стратегийн судалгааны хүрээлд судлаач хий гэлээ. Хэсэг ажиллалаа, оюуны сайхан л ажил. Тэгээд нөхөдтэйгээ хамтран Ардчиллын ордны нэг давхарт “Женко” сургуулийг байгуулж, дэд захирлын албыг хашиж байв. Дараа нь сургуулиа хотын Боловсролын газар луу нүүлгэж, тэндээ 1997-1999 онд ажилласан. Дараа нь Соёлын гавьяат зүтгэлтэн Ц.Балдорж, Боловсролын сайд асан, философийн шинжлэх ухааны доктор Н.Уртнасан нарын хамт “Оюуны өргөө” дээд сургуулийг байгуулж, захирлаар нь томилогдсон. Анх “Оюуны өргөө”-гөө Гандантэгчэнлин хийдийн дэнж дэх Хүүхдийн эмнэлгийн байранд нээсэн. Дараа нь Драммын театрын урд талын байранд нүүж байлаа.

Сонин л түүх байна. Аав, ээжийнхээ тухай дурсахгүй юу?

-Ээж минь нуруу, нугасны гэмтэлтэй, зургаа, долоон жил хэвтэрт байж байгаад 1997 онд бурхан болсон. Би хотод алба хашихын зэрэгцээ хагас сайн өдөр бүр ээжийгээ эргэхээр нутаг руугаа явдаг байв. Улаанбаатараас Өвөрхангай аймгийн Сант сум ороход 380 км зайтай. Хотоос эм, тариа эсвэл шим тэжээлтэй хүнс, гурил, будаа авч, 15.00 цагийн үед гараад 00.00 цагтай уралдан Сантад очдог байв. Очих бүрдээ ээжийнхээ боолтыг сольж, тариа хийнэ. Тэр оройдоо хоноод маргааш нь үдээс хойш замд гарч, шөнөдөө хотод ирдэг байв. Даваа гарагийн өглөө ажил дээрээ яг гозойно. Энэ маягаар ээжийгээ өөд болтол нь чадахаараа асарсан. Аав, ээж ертөнцөд ганц л удаа заяадаг учраас байнга асарч тойлж, санаа сэтгэл тавьдаг байлаа. Ээж минь ч надад буян хийжээ үлдээсэн. Сайн нөхөд, сайхан хамт олон, түшигтэй хань, хүн чанартай дарга нарын хүчээр энэ бүхний ард гарсан. Аавыгаа амьд сэрүүнд нь Монгол Улсын генерал цол хүртэж баярлуулсан.



Зүүн гар талаас: Чөлөөнд байгаа хошууч генерал Ц.Цэрэндагва, дэслэгч генерал Ц.Дашзэвэг, Ц.Тогоо, хошууч генерал Д.Бадам

Та өөрөө ч их баярласан биз?

-Би амьдралдаа олон л шагнал авсан. Хоёрт нь л илүүтэй баярласан. Эхнийх нь АНУ-ын Хүндэтгэлийн одонг авахдаа асар их талархсан. Батламжид нь “Монгол Улсын Зэвсэгт хүчний орчин үеийн болгож, олон улсын түвшинд өрсөлдөхүйц болгосны дээр дэлхий дахины аюулгүй байдалд оруулсан хувь нэмрийг үнэлэв” гэж бичсэн байв. Монгол цэргүүдийнхээ хүчээр бид дэлхийд хувь нэмрээ орууллаа гэж бодсон. Хоёр дахь нь 2008 онд Монголын менежментийн холбооноос намайг шилдэг менежерээр шалгаруулсан. Шагналаа авах үеэрээ урд нь шалгарсан хүмүүсийн танилцуулгыг харсан. Монгол Улсын хөгжилд үнэхээр хувь нэмэр оруулсан хүмүүс байлаа. Ажлыг минь дүгнэж, удирдагч талаас нь үнэлсэн байсан. Төрөөс гадна нийгэм намайг үнэлсэнд туйлын их баярласан.

Эхээсээ хэдүүлээ вэ?

-Би эхээс есүүл. Нэг эгч, долоон дүүтэй. Өдгөө бүгд амьд сэрүүн, дарга, цэрэг болж, төрийн өндөр, албан тушаал хашаагүй ч амьдрал нь боломжийн яваа. Зарим нь нутагтаа мянгат малчин болсон. Мөн сумын ИТХ-ын дарга хийсэн хүн ч бий. Хамгийн гол нь эрүүл саруул, үр хүүхдүүдтэйгээ энх тунх аж төрж буй. Манай аав, ээж малчин удмын хүмүүс. Аав минь сумын найм, аймгийн тав, улсын аваргын болзлыг гурван удаа хангасан, Монгол Улсын аварга малчин. Тэр хэрээрээ биднийг ажилч, хичээнгүй, монгол ахуйд ойр, малд нүдтэй өсгөсөн. Ээж минь нутаг орондоо алдартай, хамгийн сайхан цагаан идээ, цай ундтай хүн байлаа. Одоо ч дүү нар маань нутагтаа хамгийн сайхан айраг, цагаатай гэж магтуулдаг. Энэ бол аав, ээжийн минь буян. Өнөөдрийг хүртэл буяныг нь эдэлсээр явна даа.

Олон хүүхэдтэй айлд эерэг энерги хуралддаг гэдэг дээ. Бага насныхаа тухай дурсвал ...

-Аав цэргийн албанаас халагдаад сумандаа нэг хэсэг туслах нягтлан хийсэн. Дараа нь дэлгүүрийн худалдагч боллоо. Эгч, би, доороо нэг, хоёр дүүтэйгээ л байсан үе. Би дэлгүүрээр нь орж алим, хатсан жимснээс авч найз нөхдөдөө тараана. Аавыгаа байнга “шатаана”. Нэг удаа өр тэмдэглэдэг дэвтрийг нь авч, баахан зураг зурж, найз нөхдөдөө өгөөд алга хийчихсэн. Тэгээд аав өрөнд орж, ажлаасаа гарсан юм. Хөдөөнөөс баахан эр хонь тууж ирээд хоршоонд тушааж, мөнгийг нь өрөндөө өгч байсныг би сайн санаж байна. Тэгээд хөдөө мал дээр гарсан юм. Олуулаа байдаг айлын хүүхэд ямар байсан тэр л жишгээр өссөн. Том тогоо дүүрэн хоол хийнэ. Аавд түрүүлж аягалаад гэрээрээ хооллоно. Тогоонд хоол үлдвэл айлын том эрэгтэй хүүхэд гэдэг утгаар нь ээж надад нэмж өгдөг сөн. Мөн гэрийнхээ гадна ажлыг би хийнэ. Адуу малдаа явж, хонь хяргана, гэр барина. Гэрээ хураах, тэмээнд ачаалахаас авхуулаад нүүж суух ажлыг аавтай хамт хийдэг. Шинэ газар ирээд ханаа дугуйлж, уни өлгөөд, дотор бүрээс, дээрээ татах зэргээр гэрээ торох юмгүй барьчихна. Бас нэг том үүрэг нь даага уналгад сургана. Тэр чинь хөөрхөн том шалгуур. Зоригтой байж, тэнцвэрээ олох, унасан ч хашраагүй байх гээд олон зүйлд сургасан даа, намайг. Энэ бол насан туршийн боловсрол, амьдралыг таниулах аав, ээжийн ухаан байж.

Айлын том алганы амт их үздэг байсан гээд л таны үеийнхэн ярьдаг юм билээ ...

-Аав гар хүрэх нь битгий хэл загнахгүй талдаа. Их зөөлөн. Ээж бол хааяа ширүүлнэ. Их хатуу шүү дээ. Сумын төвд байхдаа асар их явдаг байлаа. Хүүхэд юм хойно замдаа найзуудтайгаа таараад тэргээ хаяхдаа тоглоод алга болчихно. Ард ээж гал дээр тогоогоо тавьчихсан хүлээгээд сууна. Гэнэт санаад эргэж гүйж ирнэ. Тэгээд л арьсаа хуулуулдаг байлаа. Тиймээс ээжээс их эмээдэг. Амьдрал дээр нэг нь жаахан хатуу байхад нөгөөх нь зөөлөн байхгүй бол болдоггүй юм шиг байна лээ.

Хэдэн настайдаа сургуульд орсон бэ?

-Сант сумын сургуульд найман настайдаа орсон. Ангиас хоёр, гурван хүүхэд л гайгүй сулна. Тэдний тоонд би багтдаг. Миний үеийнхэн тэрхүү сургуулийн анхны наймдугаар ангийн төгсөгчид. Анхных болохоор бэрхшээл гарна. Математикийн багшгүй бүтэн жил явсан. Төгсөхөөс сар гаруйн өмнө аймгаас багш ирж заасан. Одоо төгсөх ангийн сурагчид математикийн багшгүй бол том хохирол биз. Сурагч байхдаа яагаад ч юм, нийгмийн ухааны хичээлд татагддаг байв. Манай наймдугаар ангийн төгсөлтийнхөн олонх нь гадаад, дотоодод техник мэргэжлийн сургууль сонгож байсан. Зарим нь цэрэгт явсан. Цөөхөн нь мал дээр гарсан байх. Би гадаадын ТМС-д сурчих санаатай байв. Гэтэл багш минь суурлага сайтай тул аймгийн 10 жилийн сургуульд сур гэлээ. Ингээд аймаг явсан. Одоо зөвлөгөө өгсөн тэр багшдаа их баярладаг. Орос хэлний хичээлдээ сайн тул аймгийн олимпиадад хэд хэд түрүүлсэн. Тиймээс гадаад хэлний багш болохыг мөрөөддөг байв. Харамсалтай нь, аймагт ирсэн ганц хуваарьт багтаж чадаагүй. Цэргийн сургуулийн улс төрийн анхны ангийн хуваарийг сонгов. 1972 оны наймдугаар сарын эхээр сургуульдаа очлоо. Очтол хугацаат цэрэг шиг, үс хусаад л шууд карантилсан. Тэгэхээр нь эргэлзэж, эргэлзэж нутаг руугаа буцчихав. Нутагтаа ирээд байж байтал наймдугаар сарын дундуур хэсэг хүүхдүүд хот яваад сэтгэл эмгэглээд нэг л биш. Ингээд буцаад цэргийн сургуульдаа очтол “Хуваарь дууссан, хувийн хэргээ ав” гэлээ. Хүүхэд юм болохоороо гайгүй сурагатайдаа найдаад өөр сургуульд бариад очвол авчих байх гэж бодсон уу “Хувийн хэргээ хаанаас авах вэ” гэж асуутал нийгмийн ухааны тэнхимээс ав гэдэг юм байна. Нийгмийн ухааны тэнхим рүү очтол нэг эмэгтэй байна. Хувийн хэргээ сураглалат, тэнхимийн даргаас асууна гээд өгсөнгүй. Тэр дарга нь Л.Дамбийням багш. Л.Дамбийням багш хувийн хэргийг минь сөхөж хараад “Чи манайд сурах ёстой хүүхэд байна” гээд авч үлдсэн. Ингэж хувь заяа намайг цэргийн амьдрал руу хөтөлсөн юм. Цэргийн сургуулиа төгсөөд Дорноговь аймгийн Зүүнбаянгийн дивизид хуваарилагдсан. Тэнд очиход захирагч Ц.Шухар дарга их сайхан хүлээн авч, өөрийн хүүхэд шиг хандсан. Эхнэр нь ч ялгаагүй. Тэндээ нэг жил ажиллаад албан тушаал дэвшин, нийслэлд Сургуулийн батальонд салбарын орлогчоор очсон. Д.Бямбаа захирагчийн орлогчоор жил гаруй хугацаанд ажилласан. Энэ хүн бас надад мэддэг, чаддаг зүйлээ харамгүй заасан. Ингээд ОХУ руу Цэргийн академи явсан юм.

Тэр үед цэргийн сургууль төгсөөд зургаан жил ажилласан ахмад, түүнээс дээш цолтой хүмүүс академид суралцдаг байв. Харин би гурван жил ажиллаад Орос улс руу явсан. Хойно академид сурч байхдаа сайхан нөхөдтэй учирсан. Өмнө нь Орос сургууль төгссөн Н.Жалбажав, Р.Төмөрчөдөр нар орос хэлэндээ ус цас. Дотооддоо дээд сургууль төгссөн учраас миний орос хэлний дуудлага гавихгүй. Би их насанд уралдаж байгаа даага шиг амьтан байлаа. Тэдний түвшинд хүрэхийн тулд хичээх хэрэгтэй болсон. Ингээд Н.Жалбажавтайгаа хамт академид онц төгссөн. Бид хожим генерал болсон.

Цэргийнхний гэргий нар нөхрөөсөө нэг цолоор илүү цолтой байдаг гэсэн яриа байдаг даа. Танай “жанжин” ямар мэргэжилтэй вэ?

-Миний эхнэр санхүүч мэргэжилтэй. 40 гаруй жил хил манасан хурандаагийн охин. Манай сургуулийн ойролцоо амьдардаг байсан тул оюутан ахуйдаа танилцаж, улмаар ханилсан. Насаараа намайг дагаж, хөдөө гандаж, хээр хөхөрч, уналт, амжилт гээд бүх зүйлд хамт зүтгэсэн. Зүүнбаянд цэргийн гал тогоонд бэлтгэгчээс эхлээд касс, нягтлан гэдэг олон ажил сольсон. Гадаадд сурахаар явахад бас л хамт явсан. Би АНУ-ын Төвийн командлалд Үндэсний ахлах төлөөлөгчөөр гурван жил орчим ажилласан юм. Амьдралдаа өгсөж, уруудаж явсаар өнөөдөртэй золгож дээ.

Харин ч сонирхолтой амьдарсан юм биш үү. Ялангуяа тэтгэвэрт гарсныхаа дараа. Хувийн хэвшилд ажиллаад, жагсаалдаа эргэн ирэхэд өөр болсон байв уу?

-Би тэтгэвэртээ гараад хувийн хэвшилд орсон. Женко Х.Баттулга, Ц.Балдорж гээд “аваргуудтай” ажиллалаа. Тэд арай өөрөөр сэтгэнэ. Шинийг олж харах өнцөг нь их өвөрмөц. Би өөрийгөө хөгжүүлэхэд анхаарсан. Тухайлбал, тэтгэврийнх гэж өөрийгөө голлолгүй англи хэл сурахаар зүтгэсэн. Мөн Голландын Удирдлагын академийн менежментийн курст сурлаа. Дараа нь Зэвсэгт хүчний Жанжин штабт очихдоо өмнөхөөсөө өөр сэтгэхүйтэй ажилласан. Хуучин нэг хашаанд бүхнийг зангидаж ажилладаг байсан бол гадаад харилцаагаа тэлэх, хүнээ урамшуулах, ажлыг нь үнэлэхэд суралцсан. Шинэ зүйл хийхийг эрмэлзэж эхэлсэн минь дээрх “аваргуудын” нөлөө, хувийн хэвшилд ажилласны хүч. Өндөр хөгжилтэй орнуудад цэргийн хүнийг хувийн хэвшилд ажиллуулах дуртай байдаг. Сингапурт гэхэд цэргийн дарга нараа зориуд энгийн сургуульд мастер хамгаалуулдаг. “Амьдралыг тань, нийгмээ судал” гэж явуулдаг. Дараа нь 39-42 настайд нь эрт тэтгэвэрт гаргаад төрийн байгууллага, тэр дундаа яамдад газрын дарга, төрийн нарийн бичгийн даргаар ажиллуулдаг жишигтэй. Одоо бодоход би насаараа сурч мэдэхийн төлөө явжээ. Нийгмээсээ одоо ч хохрохгүйг хичээн суралцсаар байна.

“Зүүнбаян надад их зүйл өгсөн” хэмээх дурсамжийг тань уншсан юм байна ...

-1983 онд хойно академи төгсөж ирээд Зүүнбаяндаа эргэж очсон. Зүүнбаян гэдэг цэргийн том дивиз. Хэдэн мянган хүн ажилладаг, залуусыг төлөвшүүлж, хатуужуулдаг, цэргийн дарга болгодог газар. Тэнд Н.Батсүх даргын команд дор ажилласан.

Бас л туршлагатай, түшигтэй сайхан хүн. Хоёр жил алба хаагаад Цэргийн нэгдсэн дээд сургуульд Улс төрийн хэлтсийн орлогч даргаар томилогдлоо. Тодруулбал, 1985 онд нөгөө ерөөлт Л.Дамбийням багштайгаа ахин уулзсан. Л.Дамбийням багш манай хэлтсийн дарга. Захирал нь тухайн үед Р.Гаваа хурандаа байсан. Дараа нь Г.Рагчаа генералтай бас хамт ажилласан азтай хүн дээ би. Энэ хүмүүс миний амьдралд буян, хайр хийжээ өгсөн. Р.Гаваа захирал хожим генерал болсон. Надад асар их зүйл сургасан юм. Хүнд итгэдэг, хэлж ярьж сургахын төлөө гэсэн сэтгэлтэй хүмүүс байж. Одоо бодоход би насаараа сайн хүнтэй учрах тэнгэртэй төрж дээ гэж баярладаг юм.

Р.Гаваа генералд нэг их гомдсон гэж ярилцлага эхлэхээс өмнө хэлсэн. Юу болсон юм бэ?

-Би Р.Гаваа генералын шавь бас дүүгээс нь өөрцгүй болсон хүн. Амьдралд дотно сайхан нөхөрлөж, ямар ч ажилд гар нийлсэн. Сүүлд цэргийн сургуульд Сургалт, эрдэм шинжилгээний ажил эрхэлсэн орлогч захирал байхдаа багшид нэг зүйлд гомдсон юм. Би цэргийн сургуулийн орлогч захирал, дивизийн штабын даргын түвшний хүн. Дээрээс нь үр бүтэлтэй ажилласан тул ахмад, хошууч, хурандаа цолыг хугацаанаас нь өмнө авсан. Хурандаа болчихсон үедээ дотроо ОХУ-ын Жанжин штабын академид сурах хүсэлтэй. Хүмүүсийн нэрлэдгээр генералын академид сурч генерал болчих санаатай. Тэр үед Р.Гаваа генерал ЗХЖШ-ын дарга байлаа. Р.Гаваа генерал намайг мэдээж дэмжиж таараа гэж бодсон. Сурах өргөдлөө ч өглөө. Гэтэл Даваа хурандаа холбоо барьж, “Чиний өргөдөл даргын зүгээс дэмжлэг муутай байна” гэв. Би Р.Гаваа генералтай уулзахаар орлоо. Өөдөөс мань хүн “Тоого хч аспиратурт цаг алдахгүй элс. Чамаас хэн ч булаахгүй зүйл бол эрдмийн зэрэг. Алсдаа чамд хэрэг болно. Анги, сургууль аль алинд нь ажилласан дадлага, туршлага чамд хангалттай бий. Гагцхүү эрдмийн зэрэг дутаад байна” гэдэг юм байна. Хамгийн их итгэдэг багшийнхаа өөдөөс үг хэлж зурхлээгүй ч дотроо гомдсон гэж жигтэйхэн. Тэгсэн хамгийн хэрэгтэй зүйлийг Р.Гаваа генерал хэлж байж. 1997 онд тэтгэвэрт гараад сургуулиуд байгуулахад буурал багшийнхаа зөвлөснөөр хамгаалсан дэд докторын эрдэм мэдлэг хэрэг бололгүй хаачих вэ. Албан тушаалаа өгсөн ч эрдмийн цол зэрэг минь өнөөдрийг хүртэл надай хамт “явж” байна даа.

Эргээд цэргийн амьдралдаа ирэхэд юу түлхэц болсон юм бол ...

-Тэтгэвэртээ гараад эхнэртэйгээ хүнээс дутахгүй амьдарна гэж ярилцаад нэг удаагийн тэтгэмжийн мөнгөөрөө хоёр биеэ бүрэн хувцасласан. Ингээд бага сага наймаа хийж үзсэн. Нутагтаа очоод арьс шир авна. Дарайсан хөлдүү нэхийг машиныхаа арыг дүүртэл давхарлаж ачна. Замдаа нэхий гэсээд шалчийчихсан байдаг сан. Амьдралд зорилго тавьж, зүтгэхэд болохгүй юмгүй. Дараа нь их, дээд сургуулиуд байгуулсан гэдгээ дээр хэлсэн. Гэхдээ хувь заяа дахиад л намайг цэргийн амьдралд татан оруулсан даа. Хуучин МАХН (Одоогийн МАН) боловсон хүчний судалгаа маш сайн хийдэг байж. 1980-аад оны эхээр 35 настайдаа Өвөрхангай аймгийн дивизийн улс төрийн хэлтсийн даргаар томилогдсон юм. Ингэхдээ хурандаа зэрэгтэйгээр Намын төв хорооны нарийн бичгийн дарга нарын зөвлөгөөнөөр орсон. Ж.Батмөнх, Д.Моломжамц, Ц.Намсрай, П.Дамдин, Ц.Балхаажав, Б.Дэжид гуай гээд томчууд бүгд суучихсан байв. Тэр өдрийн хуралдаанаар Д.Сандаг генерал АНУ-д суух Элчин сайдын яамны II нарийн бичгийн даргаар, Сэлэнгэ аймгийн төв хүн аймгийнхаа Залуучуудын эвлэлийн хорооны I нарийн бичгийн даргаар ажиллахаар гурвуул хуралд орсон. Намын төв хорооны боловсон хүчний хэлтсийн ажилтан Лувсанноров гуай биднийг танилцуулсан. Тэгэхэд би хошууч цолтой байлаа. Ингэж 35 насандаа Намын төв хорооны мэдлийн боловсон хүчин болсон юм. Тэр үед бэлтгэсэн боловсон хүчнээ Лувсанноров гуай нэг бүрчлэн мэддэг. Тэр хүн хожим

ХИЙГЭЭД ХАЛУУН ЦЭГ РҮҮ ЦЭРГЭЭ ИЛГЭЭХДЭЭ ӨРӨВДӨЖ Л СУУСАН

МАН-ын удирдлагатай холбоотой байсан байх. Тэр мэдээллийн дагуу намайг эргэж дуудсан болов уу. Хоёрдугаарт, цэргийн албаа өгсний дараагаар залууст эх оронч үзэл, хүмүүжил төлөвшил, олгохоор зарим ТББ-тай хамтран тодорхой ажил хийсэн. Гадаадын байгууллагыг ч татан оруулсан. Н.Энхбаяр, Л.Энэбиш даргатай хамтран хэд хэдэн арга хэмжээ зохион байгуулсан. Эдгээр ажил нөлөөлсөн үү, нэг өдөр дуудаж, дэд сайд гэдэг албан тушаалд намайг томилсон.

Дуртай албаа гэнэт өгсөн. Сайхан байгаагүй биз. Гэтэл буцаад цэргийн амьдрал дуудах үед ямар сэтгэгдэл төрсөн бэ?

–Ажилгүй болох эвгүй юм билээ. Одоо бодоход 1996 онд сайд нар офицер нэг бүрийг сайн мэддэггүй байж. Явж явж эргэн тойронд байсан ойр дотнын зарим хүнээс “Албан тушаал дэвшихэд энэ надад саад болж магад”, “Цаашдаа энэ хүн миний гол өрсөлдөгч болно” гэсэн богино бодлоор дээшээ мэдээлэл өгсөн байдаг. Намайг хурандаагаараа дуусна гэж бодсон юм болов уу. Батлан хамгаалахын дэд сайд болоод эргээд ирэхэд нөгөө хүмүүс өөрсдөө өргөдлөө өгөөд алга болсон. Тийм хүмүүс эргээд хүний нүүр харж чадахгүй, их хэцүү байсан биз ээ. Уг нь би юу ч хэлээгүй юм шүү дээ.

Тийм хүмүүс таныг бүр хурцалсан юм биш үү?

–Үүнээс гадна Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга болоод Батлан хамгаалахын найман сайд, Монгол Улсын гурван Ерөнхийлөгчтэй ажилласан. 2002-2009 онд энэ албыг хашсан. Тэгэхэд Ж.Гуррагчаа сайдаас бусад нь намайг мэддэггүй, сургаар сонссон хүмүүс байсан. Тиймээс ерөнхий цэргийн хүн биш, улс төрийн анги төгссөн гэдэг эхэндээ голонгүй л байсан. Би дотоодод улс төрийн анги дүүргэсэн ч Орост цэргийн академи төгссөн. Ерөнхий цэргийн анги, байгууллага удирддаг дарга нарын түвшний цэргийн боловсролыг эзэмшсэн. Дараа нь дахин цэргийн сургуульд зургаан жил шахам нэгдүгээр орлогчоор ажилласан туршлагатай. Сайд нар янз бүрийн хүн дагуулж ирнэ. Ганц хоёр хүнийг нь ажилд авна, заримыг нь авахгүй. Гэхдээ сайд нартайгаа ойлголцож, сүүлдээ найз болдог. “Эрэл”-ийн Б.Эрдэнэбат сайд болоходоо намайг хална, солино гэж их үзсэн. Хэдэн сар болоод ажил төрлөө ойлголцоод ирэхээр “Түшиг тулгуур боллоо” гэж ярих жүжээтэй. М.Сономпил, Ц.Шаравдорж, Ж.Батхуяг, Л.Болд зэрэг сайдтай ажилласан. Ажлаа хийгээд зөв явбал ойлголцдог л юм. Хүний амьдрал баялаг учраас хүн чигээрээ л дуусах нь чухал юм билээ. Өнөө маргаашаа бодоод урваж шарвах хүнийг бишгүй л үзсэн. Эцэстээ сайн юм авчирдаггүй юм билээ. Би хүнд муу санаж чаддаггүй. Тиймээс шинэ ажил аваад зөв менежмент нийгмийг хичээсэн. 2004 онд ангиудын ажлыг анх удаа дүгнэж, захирагч нарт хувьд нь машин бэлгэлзлээ. Япон, Сингапур зэрэг газарт амраасан. Заримд нь цэргийн анги, байгууллага эзэмшиж байсан газарт амины орон сууц барих эрх олгосон. Алба хаагчдын нийгмийн асуудалд анхаарч эхэлсэн. Түүнээс анх надад Зэвсэгт хүчний Жанжин штабын даргаар ажиллах санал тавихад би татгалзаж явсан хүн.

Гэхдээ та энэ албыг бүр есөн жил хашсан байна шүү дээ ...

–Би АНУ руу англи хэлний сургуульд явсан юм. 2002 оны 3 дугаар сард явахаас урд дарга нар дуудаад Зэвсэгт хүчний Жанжин штабын даргаар ажиллуулахаар санал асуусан. Заавал Жанжин штабын академи төгссөн хүн энэ албанд очдог бичигдээгүй хууль Монголд бий. Гэтэл би улс төрийн анги төгссөн. Тэр үед Жанжин штабын академи төгссөн С.Баасанхүү, Ч.Улаанхүү, Б.Шагдар гээд чадвартай генерал олон байв. Тиймээс “Би энэ албыг авахгүй” хэмээн шууд татгалзсан. Тэгээд зорьсон газар руугаа 40 нас гарсан хойноо англи хэл сурахаар явсан. Дараа нь тэндээ Батлан хамгаалахын нөөцийн удирдлагын курс төгслөө. Эргээд ирэхэд ЗХЖШ-ын даргаар томилсон. Баярлахаас илүүтэй түмэн зүйл бодож, стрессдсэн. Хаа очиж

сайхан хамт олон тоссон. Тиймээс шинэ зүйл санаачилж хийхийг эрмэлзсэн. Даацтай ажил олныг хийсэн. Гэхдээ үүнийгээ бус, ганц нэг өөр хөгжилтэй зүйл ярьж. АНУ-д хуралд явж байхдаа хүүхдүүд бөмбөртэй жагсаалаар хоорондоо өрсөлдөхийг харсан. Монголд ирээд Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжмийн дарга, хурандаа Ё.Ганбатыг дуудаад манай анги, нэгтгэлд бөмбөр бий юу гэж асуусан. Ганц том бөмбөрөөс өөр юм алга гэв. Тиймээс БНХАУ-д суугаа цэргийн атташөд бөмбөр захин авчруулж, хөгжимчдийг сургасан. Одоо жагсаалын урд цэргүүд бөмбөр тоглодог болсон. Тухайн үедээ хүмүүс шинэ зүйл гээд сайхан хүлээж авсан. Нөгөө талаараа хүмүүс улс төрийн жагсаалд манай бөмбөрийг ашиглаж эхэлсэн. Үүнээс болж Ерөнхийлөгчид загнуулж билээ. Дараа нь Шри Ланка руу энхийг сахиулах ажиллагааны арга хэмжээнд оролцохоор явлаа. Тэнд ууланд усан цахилгаан станц барьчихсан. Хажуугаар нь “кэмп”-тэй. “Кэмп”-ээ сургалтын төв болгочихсон байсан. Уулын энгэр дэх жижиг толгодыг тэгшилж хайрга асгаад жагсаалын талбай хийжээ. Монголд ирээд үзэж харснаа шууд л хэрэгжүүлэхээр яарсан. Тавантолгойн сургалтын төвийг байгуулах ажилд орсон. Эхлээд хайрга дэвсэж жагсаалын талбай хийлээ. Тэгэхэд манай агаар хуурай учраас алба хаагчид жагсаалаар явахаар хайрга үсэрч нүд рүү нь орчих гээд болдоггүй. Шри Ланк улсад өдөр болгон шахам бороо ордог, чийглэг учраас хайрга доошоо суудаг юм билээ. Ингээд хайрга авч, цемент болгосон. Бас нэг удаа Америкийн цэргийн баазад очсон. Тэндхийн цэргүүд өглөөдөө улсынхаа Төрийн далбааг мандуулж байсан. Монголд ирээд анх удаа цэргийн ангиудад Төрийн далбаагаа өглөө мандуулж, Төрийн дуулал эгшиглүүлж, орой бие бүрэлдэхүүн далбаагаа буулгаж ёслоод тардаг журам тогтоолоо. Далбаагаа мандуулж, Төрийн дуулал эгшиглүүлэх нь хүнд асар их зүйл өгдөг. Үүнийг дагаад Төрийн далбааны өдөртэй болсон. Ямар сайндаа манай ар талын газрын дарга, орлогч Д.Бадам генерал дээхэн үед “Даргыг үүрэг өгөхөөр урамтай. Сонсоод суугаад баймаар. Бусад даргын өгсөн үүрэг уйтгартай” гэж ярьсан удаатай.

Та чинь бас их ардчилалч гэл үү?

–1990 онд ардчилал анх армид гарсан нь “офицерын хурал” байлаа. Энэ хурлыг санаачлагчдын нэг нь би. “Ардын эрх” сонинд Философийн ухааны доктор, гавьяат багш, бэлтгэл дэд хурандаа Б.Галиндэв бид хоёр анх “Армийн тухай” бүтэн нүүр материал хэвлүүлсэн. Агуулга нь “Социализмын арми хүйтэн дайны үеийнх шиг хэт данхилаа. Орчин цагийн нийгэмд тохирсон шинэ арми байгуулах ёстой” гэж бичсэн. Залуучуудыг хөгжүүлэхгүй, дэмжихгүй байна. Үргүй зардал их байгааг шүүмжилсэн. Нийтлэлийн дараа хүмүүсийн нүд орой дээрээ гарч, чих нь дэлдлийн. Ингээд хурал хуй зохион байгуулж яваад Ерөнхийлөгч П.Очирбаттай хоёр дахич уулзсан. П.Очирбат гуай “Та нарыг Чилийн цэргийн хунт шиг юм хийж байна гэж яриад байсан, зөв ажил хийж байгаа залуус байна” гэж дэмжсэн. Энэ үед надтай Б.Галиндэв, Н.Жалбажав, Б.Бадарч, М.Борбаатар, Ш.Эрдэнэбаяр, Д.Мархаахүү нар санаа нийлж хамтран ажилладаг байлаа.

Гүзээтэй хурандаа нар олширсон гэдэгтэй санал нийлэх үү?

–Офицер, ахлагч нарт бие бялдрын өндөр шалгуур тавих ёстой. Армид бие бялдрын хувьд ямар түвшинд байна, биеийн ерөнхий үзүүлэлтүүд нь ямархуу байгааг зургаан сар болоод шалгадаг. Хэрвээ шаардлага хангахгүй бол хугацаа өгдөг. Гурван сарын хугацаанд засаж чадахгүй бол “Та армид байх боломжгүй” гэж хэлээд явуулах ёстой. Энэ шаардлагыг ягштал баримталмаар. Одоо тайван цаг болохоос эцсийн эцэст эх орон дуудахад цэргийн амьдралд би ялах уу, чи ялах уу, хэн амьд үлдэх вэ гэдэг асуудал тулгарна. Тиймээс мэргэжлийн хувьд ч, бие бялдар, ёс суртахуун, оюун санаа аль алианаар нь бэлтгэгдэхгүй бол ялагдана. Магадгүй онцгой нөхцөл үүсэхэд

шүхрээр буу гэвэл бууж таараа. Буудлага хий гэвэл хийх үүрэгтэй. Дарга гээд ард нь үлдэхгүй. Дарга хамгийн түрүүнд цагийн байдлыг үнэлж, шийдвэрээ гаргаад манлайлах учиртай. Өөрийнхөө гүзээг захирч чадахгүй бол бусдыг захирах тухай бодоод ч хэрэггүй. Дэлхийн аль ч оронд, тухайлбал, хятадад цэргүүддээ асар өндөр шаардлага тавьдаг. Тэнд нэг ширхэг ч гүзээтэй дарга байхгүй.



Япон, Солонгос, Америкийн арми бүгд адилхан.

Энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлснээр армийн нэр хүнд сэргэсэн гэж ойлгодог.

–2002 оноос энхийг сахиулах ажиллагаанд оролцлоо. Гурван тивийн 11 оронд нийтдээ 18000 гаруй цэргийн алба хаагч үүрэг гүйцэтгээд байна. Үр дүнд нь цэрэг армид хандах нийгмийн хандлага өөр болсон. Одоо бол Монгол цэргүүд энхийг сахиулах ажиллагаанд оролцоод нэрээ гаргачихлаа. Манай залуус ямар ч үүрэг биелүүлэх чадвартай, тэсвэр тэвчээртэй, зоригтой, авхаалжтай. Тухайлбал, Ирак, Афганистан улсад болсон халдлагын үеэр манай цэргүүд энэ чадвараа баталсан. Судан улсад болсон үйл явдалд монгол цэрэг манлайлж оролцсон. Намайг ЗХЖШ-ын даргаар томилогдох үед анхны хоёр цэргийн алба хаагч энхийг сахиулах ажиллагаанд явсан байсан. 2003 онд Ирак дахь ажиллагаанд манай Зэвсэгт хүчин нэгдсэн. “УАЗ-469” машин дотор элстэй шуудай хийн, хамгаалалт маягтай болгоод цэргүүдээ явуулахдаа өрөвдөж л байлаа. Зэвсэг муутай, техникүүд нь хуучирч элэгдсэн учраас дотроо сэтгэл зовниж суусан. Гэвч манайхан үүргээ сайн биелүүлсэн. Энэ нь зөвхөн цэргийнхэнд урам өгөхөөс гадна Монгол Улсын нэр хүндийг өндөрт өргөсөн. Өнөөдөр монгол цэргийг авья, ажиллуулъя, энхийг сахиулах ажиллагаанд оролцуулъя гэсэн хүсэлт их байна. Бид өөрсдөө сургах, зэвсэглэл, техникээр хангах асуудалд анхаарах ёстой болов уу. Мянганы сорилтын сангийн захирал, Элчин сайд Данилов хэлэхдээ “Мянганы сорилтын сангаас олгож байгаа буцалтгүй тусламж бол монгол цэргийн гавьяа” гэсэн.

Энхийг сахиулах ажиллагаанд манай цэргүүд оролцож эхлэлийг та тавьсан гэсэн үг үү?

–Энхийг сахиулах ажиллагаанд орох асуудлыг анх хөндсөн хүмүүс нь цэргийн сэтгүүлчид. 1980 оны дунд үед “Улаан-Од” сонинд анх эл асуудлыг хөндсөн байдаг. Дараа нь ЗХЖШ-ын дарга асан, дэслэгч генерал Ч.Пүрэвдорж энэ талаар өгүүлэл бичсэн. Харин Иракт монгол цэргийг үүрэг гүйцэтгүүлэх талаар тухайн үеийн төр, засгийн удирдлага Батлан хамгаалахын сайд бид хоёрыг дуудан Америкийн тэргүүлсэн эвсэлд яаж туслах вэ гэж ярилцсан. Агаарын орон зайгаа ашиглуулж болох уу гэсэн. Ямар ч боломжгүй, Хятад, Оросын дээгүүр гарна гэж байхгүй. Агаарын орон зай хоёр талаасаа хаалттай. Зэвсэг, техникээр туслах боломжгүй. Ингээд зөвлөлдсөөр 2003 онд цэргээ Иракт оруулсан. Иракт цэрэг оруулж, Америктай эвсээд ирэхээр Орос, Хятадын хандлага өөрчлөгдсөн. Оросууд манайхыг нэг хэсэг “хаячихсан”. Тэнд сургадаг хүний тоо цөөрч, зөвхөн Жанжин штабын академид нэг хүн сургахын тулд сард 1000 гаруй ам.доллар төлж байв. Улмаар сая шахам ам.долларын өрөнд орчихсон үе. Хятадын талаас ч гэсэн. Иракт цэргээ оруулсан

нь манай цэрэг армийн үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэхээс гадна олон улсын түвшинд Монгол Улсын нэр хүндийг өргөсөн том үйл явдал болсон юм.

Зэвсэгт хүчинд маш том ололт байж дээ.

–2002 онд олон улсад ажиглагчаар явуулах гадаад хэлтэй цэргийн алба хаагч ховор байдаг байв. “Хааны эрэлд” сургуулийг уржнан жил зохион байгуулахад нь

болчлоод байхад яаж ийгээд алба хаагаад яваад байх сонирхолтой. Мөнхийн алба шиг санаад, ар өврөөр гүйгээд л би дарга, генерал болох ёстой гэх юм.

–Найранд гурван дуутай, наадамд гурван даваатай байх нь ...

–Дуулна аа дуулна, ор тас хоосонгүй. Олонд хүрсэн алдартай шүлэг байхгүй ч өөртөө бичдэг. Хааяадаа сэтгэлээ хөглөчихдөг

очлоо. Сургууль удирдах түвшний боловсон хүчин олон бэлтгэгдэжээ. Өөрөөр хэлбэл, олон улсын 10 гаруй мянган алба хаагч оролцож буй сургуулийг монгол офицер чадварлаг удирдаж байна. Манай цэргийнхэн Америкт 2–3 шатны сургууль төгсөхөөс гадна Япон, Турк зэрэг олон оронд офицеруудаа бэлтгэж байна. Сүүлийн жилүүдэд манайхан 20 гаруй оронд цэргийн бүх шатны сургуульд сурч буй. Хүнээ бэлтгэх тал дээр Батлан хамгаалах салбар бусад салбараас илүү хөгжсөн. Бие бялдрын хувьд ч гологдохгүй. Энхийг сахиулах ажиллагаанд ихэвчлэн ахлагч нар явдаг. Энэ хүмүүсийг мэргэжлийн цэрэг гэж хэлнэ. Харьцангуй бие бялдрын хөгжил сайтай. Хэнээс ч дутахааргүй бэлтгэгдсэн. Иракт болсон халдлагын үеэр Г.Азаяа цөмрөөд орж ирсэн дайсны жолоочийг анхны буудлагаар онож устгасан. Энэ бол сайн бэлтгэгдсэний шинж.

Генералын зангарга гэж юу юм бэ?

–Монголд жудагтай, эр хүн шиг, зангаргатай генерал олон. Сонсогч ахуйдаа хурандаа генерал Ж.Ёндонг шүтэж явлаа. Агуу жанжин байв. Намайг цэргийн сургуулийн гуравдугаар дамжаанд байхад манай сургуулийн захирлаар ирсэн. Ж.Ёндон генерал цэргийн дарга ямар байх ёстойн үлгэр жишээг харуулсан. Асар өндөр мэдлэгтэй. Ажлаа ягштал хийдэг. Цэргийн төдийгүй урлаг, соёлын авьяастай, харилцааны соёлтой, их мэдрэмжтэй. Дараагийн үе нь хошууч генерал Р.Гаваа. Р.Гаваа генерал Ж.Ёндон генералын захиргаанд байсан хүн. “Стиль” нь үндсэндээ адилхан. Халуун сэтгэлтэй, ясны генерал. Цэрэгжилт, жагсаалч байдал, урлаг, спорт зэрэг бүх зүйл нь жигдэрсэн хүн. 1980-аад оны дунд үед англи хэлтэй хүн ховор байв. Тэр үед генерал Р.Гаваа, Г.Рагчаа, шинжлэх ухааны доктор, хурандаа Ш.Паламдорж нар МУИС-ийн англи хэлний дамжаанд сурсан байдаг. Ш.Жадамба, Ц.Дашзэвэг, Б.Шагдар нарын генерал оюунаараа манлайлж, цэргийн дарга ийм байх ёстой гэж биеэрээ үлгэрлэсэн. Намайг ЗХЖШ-ын даргаар очиход миний нэгдүгээр орлогч Б.Шагдар генерал байв. Бид үзэл бодол таарахгүй, санал зөрөлдөөд болдоггүй. Би шууд “Тантай ажиллахгүй, ажлаа өг” гэсэн. Манай хүн “Дарга тэгж байгаа бол би юу хэлэх вэ” гээд өргөдлөө өгсөн. Тавь гаруйхан настай л байсан. ЗХУ-д Жанжин штабын академи төгссөн, Зүүнбаянгийн дивиз командалж явсан хүн. Парадыг хэцнээн жил сайхан командлав. Б.Шагдар генерал гоншигноогүй. Би маш их хүндэлсэн. Тиймээс би эргэж урьж, ЗХЖШ-ын Шинжлэх ухаан, технологийн зөвлөлд хамтарч ажилласан. Манай хүн чамд голмдсон, эсвэл чамайг уучиллаа гэх ганц үг ч унагаагүй. Тийм сайхан. Эднээсээ бишгүй эрдмийг сурсан. Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж ирээд 2009 оны 7 дугаар сарын 10-ны өдөр буюу наадмын урд өдөр ажлаа өг гэхэд нь би бас үг дуугүй биелүүлсэн. Одоогийн зарим хүмүүсийг харахаар нас сүүдэр нь

юм. Анги, нэгтгэлд байхдаа концерт ч найруулж, хөтлөн, ханын сонин хийж, зурж явлаа.

Монгол цэргийн нэгдсэн холбоог байгуулалцсан талаараа мэдээлэл өгөхгүй юу?

–2019 оны 4 дүгээр сард холбоогоо байгуулсан. 6 дугаар сараас нь үйл ажиллагаагаа идэвхжүүлээ. Оны босгон дээр ажлаа дүгнэхэд богино хугацаанд чамгүй зүйл хийжээ. Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудаас тэтгэвэрт гарсан 18000 гаруй хүн бий. Тэдний 57 хувь нь 60 хүрээгүй эрэгтэй, 55 хүрээгүй эмэгтэйчүүд. Энэ хүмүүс ахмадын хөнгөлөлтөд хамрагддаггүй. Наад зах нь тэтгэвэртээ гарсан хэрнээ автобусанд мөнгөө төлж суудаг. Амралт, сувилалд явсан ч хөнгөлөлт эдлэхгүй. Энэ чиглэлээр судалгаа хийсэн. Ялангуяа ахлагч нар анги, нэгтгэл дамжиж томилогдсоор тэтгэвэртээ гарахдаа орон байргүй үлдэж байна. Энэ хүмүүсийн нийгмийн асуудлыг шийдэхээр Удирдлагын академитай хамтран цөөнгүй хүнийг сургалтад хамруулсан. Эхнээс нь 40 гаруй хүнийг ажилд оруулсан. Цэргийнхэн очсон газраа хариуцлагатай сайн ажилладаг. Зарим цэргийн байгууллага эмэгтэйчүүдийг жирэмсний амралттай байхад нь цолны нэмэгдлийг өгдөггүй байж. Үүнийг нь цэгцэлсэн. Улсын хэмжээнд эмэгтэй цэргийн алба хаагчдын болон түрүүч нарын чуулга уулзалтыг зохион байгууллаа. Тэдэнтэйгээ залууст эх оронч үзлийг төлөвшүүлэх талаар ярилцсан. Эх орноо хөгжүүлбэ гэвэл хүн бүр зүтгэх учиртай. Шүүмжлэх амархан. Нэг ч гэсэн залуу тамхины ишээ хаяхгүй байхад сургаа гэх зэргээр хэлэлцсэн. Үр дүнгээ өгсөн болов уу. Тэд өндөр сэтгэгдэлтэй үлдсэн. Өнгөрсөн зун “Шонхор” зусланг түшиглэн 1000 сурагчдад эх оронч үзлийг төлөвшүүлэх сургалтыг зохион байгууллаа. Аль ч газар сахилга, зохион байгуулалт хэрэгтэй. Энэ мэтээр манай холбооны ажил олонд танигдаж эхэлсэн. Хүмүүс их хандах боллоо. Зарим нь аавынхаа дурсамжийн номыг авчирч өгсөн. Одон, медаль, байр сууц хүсэх хүн ч ирэх юм. Сэтгэл санаагаа нээж, асуудлаа ярьж ирэх хүн олширсон. Одоо манайхан дарга ирээд ямар үүрэг өгөх бол гэж хүлээдэг. Энэ нь надад урамтай байдаг. Өглөө зургаан цагт босоод интернэт орж дэлхий ертөнцөд юу болж байгааг уншдаг. Мессенжер, вайбераа шалгана. Зүгээр суух дургүй. Байнга бодож сэтгэхийг эрмэлздэг.

Бидний ярилцлага өндөрлөх дөхөж байна. Ярилцлагын төгсгөлийн үгийг танд үлдээ ...

–Сэтгэлийн үгээ хэлэх завшаан олгосон та бүгдэд баярлалаа. Юуны өмнө намайг өдий зэрэгт хүргэсэн бүх хүн, тэр дундаа манайг хүмүүжүүлсэн захирагч, дарга, багш нар, цэргийн хамт олон, жирийн бор цэргүүддээ мэндчилгээ дэвшүүлж, сайн сайхан бүхнийг хүсэн өрөөе. Та бүхнийхээ төлөө би чадах бүхнээ хийх чин эрмэлзэлтэй байгаа шүү гэдгээ хэлэхэд таатай байна.

Д.МЯГМАРЖАРГАЛ

ХУРАНДАА ГЕНЕРАЛ Ж.ЛХАГВАСҮРЭНГИЙН ГЭГЭЭН ДУРСГАЛД


ӨВГӨН ГЕНЕРАЛТАЙ УУЛЗСАН СҮҮЛИЙН СУРВАЛЖИЛГА

Монгол Улсын тусгаар тогтнолыг хамгаалах их үйл хэрэгт оруулсан залуу жанжны гавьяаг манай ард түмэн дурсан санаж хүндэтгэдэг юм. Цэргийн явдлын яамны сайд, Бүх цэргийн жанжин, маршал Х.Чойбалсангийн 1939 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн 31 тоот тушаалаар Цэргийн улс төрийн газрын дарга, корпусын комиссар Ж.Лхагвасүрэнг орлогч жанжнаар томилон Халхын голын байлдааны фронтыг удирдуулжээ.

Тэртээ 1981 оны 12 дугаар сарын эхээр энэ эрхэм хүнтэй бид Монголын үндэсний олон нийтийн телевизийн нэвтрүүлгийн студид уулзаж сурвалжилга хийж явснаа өнөөдөр нэхэн санаж энэхүү өгүүллэг бичин сууна.

ӨВГӨН ГЕНЕРАЛТАЙ УУЛЗСАН НЬ

1981 оны 12 дугаар сарын эхээр нэгэн мартагдашгүй сонин уулзалт миний амьдралд тохиолдсон юм. ЗХУ-ын дөрвөн удаагийн баатар, БНМАУ-ын баатар маршал, Георгий Константинович Жуковын мэндэлсний 90 жилийн ой тохиож, энэ тухай нэвтрүүлэг хийх үүрэг редактор Ч.Болд



бид хоёрт оногдсон юм. Монгол киноны үзвэрийн газраас "Маршал Жуков" хэмээх гурван бүлэг баримтат киног авч бэлтгэлээ. Маршал Г.К.Жуковийг сайн мэдэх хүн гэвэл залуу жанжнаараа алдаршсан, Халхын голын байлдааны фронт дээр МАХЦ-ийн командлагч асан хурандаа генерал Жамъянгийн Лхагвасүрэн байсан юм. Ингээд бидний урилгыг хүлээн авч манай редакцын хаалгаар энгэр дүүрэн одон, медаль г я л а л з у л с а н , сэтгэлдээ баяр баясал бялхуулсан генерал Лхагвасүрэн

гуай хүрэлцэн ирж нэвтрүүлэгт оролцож билээ.

Халхын голын байлдааны фронт дээр хүнд хэцүү тулалдаануудад Монгол-Зөвлөлтийн армийн дайчид гарамгай гавьяа байгуулж, маршал Жуковтой хамт мөр зэрэгцэн ажиллаж байсан дурсамжаа хуваалцан түүний цэргийн жанжны командлах чадвар, зан чанарын тухай болон фронт дээр өрнөсөн сонин сайхан дурсамжуудыг ярилаа. Энэ тухайд, би бээр 1939 оны 6 дугаар сарын 8-ны өдөр Халхын гол руу явсан юм. Энэ үед К.Е.Ворошилов Х.Чойбалсантай Тамсагбулагт Зөвлөлт-Монголын цэргийн ангиудыг нэгтгэн Армийн нэгдүгээр бүлэг болгон зохион байгуулах тухай утсаар ярьсныг сонссон байлаа. Энэхүү бүлгийн командлалын байранд хэдэн гэр барьжээ. Тэдний нэг гэрт сууж байтал дунд зэргийн нуруутай

шингэвтэр хүрэн үстэй, хурц, цэнхэр нүдтэй нэгэн тэвхэлсэн эр орж ирсэн нь Георгий Жуков байлаа. Маршал Х.Чойбалсан энэ залуу манай армийн Улс төрийн газрын дарга, корпусын комиссар Лхагвасүрэн гэж танилцууллаа. Жуков өмнөх ширээн дээр байгаа байлдааны газрын зураг дээр хаана, юу болсон, одоо ямар байдалтай байгаа, Зөвлөлт-Монголын цэргийн нэгтгэл, анги, Японы цэргийн байрлал, дайсны болзошгүй ажиллагаа, түүний эсрэг юу хийвэл зохилтойг нэг бүрчлэн тайлбарлав. Анх харахад түүний ярьж байгаа нь эрс зоримог, шулуун хүн шиг санагдаж билээ. Цаашид энэ хүнтэй хамтран Монголын нэгтгэл, ангиудыг командлан дайнд оролцож эцсийг нь хүртэл ажилласан юм.

(Үргэлжлэл нь VII нүүрт)

ХОШУУЧ ГЕНЕРАЛ Ж.ЦЭНД-АЮУШИЙН МЭНДЭЛСНИЙ 100 ЖИЛИЙН ОЙД

Алт хэдий удсан ч өнгөө хувиргахгүй
Алдартан хэдий үхсэн ч нэр нь мартагдахгүй

ОЛОН БҮТЭЭЛЧ АЖЛЫГ САНААЧИЛЖЭЭ

Энэ онд төр, цэргийн нэрт зүтгэлтэн, хошууч генерал Ж.Цэнд-Аюушийн мэндэлсний 100 жилийн ой тохиож байна. Энэхүү түүхт ойг угтаж "Цэргийн улс төр, соёл хүмүүжлийн ажилтны нэгдсэн эвлэл" төрийн бус байгууллагаас Батлан хамгаалах яаманд албан бичиг, танилцуулга хүргүүлж, хошууч генерал Ж.Цэнд-Аюушийн дурсгалын самбарыг бий болгох, "Соёмбо" сонинд 100 жилийн ойд нь зориулсан тусгай нүүрийг бэлтгэж нийтийн хүртээл болгох, ахмад дайчид оролцсон онол, практикийн хурал, хэлэлцүүлгийг зохион байгуулах, Монгол цэргийн музейд түүний амьдрал, үйл ажиллагааг харуулсан хүндэтгэлийн булан байгуулах, "Дуула" теле сурталчлах зэрэг эрхэм генералтай хамтран ажиллаж байсан ахмадуудыг оролцуулсан нэвтрүүлэг бэлтгэх, олон нийтэд сурталчлах зэрэг ажлуудыг төлөвлөн хэрэгжилтийг нь зохион байгуулж байна.

Түүнчлэн хошууч генерал Ж.Цэнд-Аюушийн төрсөн нутаг Архангай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчид, аймгийн Засаг даргатай холбоо тогтоон түүний дурсгалыг нь мөнхжүүлэх ажлыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ мэндэлснийх нь 100 жилийн ойг тусгай хөтөлбөрийн дагуу тэмдэглэн өнгөрүүлэх, урлаг, соёлын арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөөд байна.

НАМТРЫН ТОВЧООН

Жамцын Цэнд-Аюуш нь 1920 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр Сайн ноён хан аймгийн Сүжигт бэйсийн хошуу, одоогийн Архангай аймгийн Хотонт сумын нутагт малчин ард эцэг Жамц, эх Бал нарын гэр бүлд төрсөн. Бага насаа эцэг, эхийн асрамжид өнгөрүүлсэн ба 1940-өөд оны түгшүүрт жилүүдэд эрийн цээнд хүрсэн Цэнд-Аюуш хүү Бүх цэргийн жанжны тушаалаар Архангай аймгаас цэргийн албанд татагдаж 5 дугаар дивизийн их бууны дивизионд цэрэг, бага даргын албан тушаалд эх орноо хамгаалах нэр хүндтэй албыг хашсан. Тэр бээр 1941 оны дунд үеэс 1942 оны 5 дугаар сарыг хүртэл хугацаат цэргийн алба хаажээ.

БОЛОВСРОЛ

1941-1943 онд Цэргийн

ерөнхий сургуулийн улс төрийн анги;

1947-1949 онд Намын шинэ хүчний дээд сургууль;

1955-1958 онд ЗХУКН-ын дээд сургуульд тус тус суралцаж төгссөн.

ЭРХЭЛЖ БАЙСАН АЖИЛ АЛБАН ТУШААЛ

Ж.Цэнд-Аюуш 1943 оноос эхлэн Ардын Армиуд сумангийн улс төрийн удирдагч, хорооны намын товчооны дарга, дивизийн намын ажлын зааварлагч, Ардын цэргийн Улс төрийн газрын зааварлагч, хэлтсийн орлогч, дарга, Намын төв хороонд хэлтсийн орлогч эрхлэгч, хэлтсийн эрхлэгч, Архангай аймгийн намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга, Ардын цэргийн Улс төрийн газрын даргаар гурван удаа томилогдон ажилласан. 1969 оноос БНМАУ-ын Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтний хорооны анхны даргаар ажиллаж байсан.

ЧӨЛӨӨЛӨХ ДАЙНД ОРОЛЦСОН НЬ

Ж.Цэнд-Аюуш 1945 оны Чөлөөлөх дайнд 5 дугаар дивизийн 28 дугаар хорооны намын товчооны даргаар оролцож, Өвөр Монгол ба Хятадын нутагт гурван сар шахам явж Цагаан хэрэм, Долоннуур, Жэхэ хотод очсон байна. Түүнийг Улсын Бага Хурлын тэргүүлэгчдийн 1945 оны 11 дүгээр сарын 6-ны өдрийн шийдвэрээр Чөлөөлөх дайнд эрэлхэг зоригтой, гарамгай гавьяа байгуулсны учир Байлдааны гавьяаны улаан тугийн одонгоор шагнажээ.

УЛС ТӨРИЙН ГАЗАРТ АЖИЛЛАСАН ОН ЖИЛҮҮД

1947-1951 онд МАХЦ-ийн Улс төрийн газарт хэлтсийн орлогч, 1951-1952 онд Улс төрийн газрын шинэ хүчний хэлтсийн даргаар ажилласан ба Улсыг Батлан хамгаалах яамны сайдын 1953 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 021 тоот тушаалаар Ардын цэргийн Улс төрийн газрын орлогч бөгөөд Нам, эвлэлийн ажлын хэлтсийн дарга мөн сайдын 1954 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн 048 тоот тушаалаар Ардын цэргийн Улс төрийн газрын орлогч даргаар томилогдож ажилласан.

1954-1955 онд Ардын цэргийн Улс төрийн газрын

даргаар анх удаа, 1959-1960 онд Ардын цэргийн командлагчийн орлогч бөгөөд Ардын цэргийн Улс төрийн газрын даргаар хоёр дахь удаагаа, 1962-1969 онд Ардын цэргийн Улс төрийн газрын даргаар гурав дахь удаагаа тус тус томилогдон ажилласан. Түүнийг дээрх албан тушаалд ажиллаж байх үед БНМАУ-ын Ардын цэргийн хэрэг эрхлэх яамны сайд бөгөөд Ардын Армийн командлагч, хурандаа генерал Ж.Лхагвасүрэнгийн гарын үсэгтэй тодорхойлолтоор БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1965 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 139 дүгээр тогтоолоор хошууч генерал цол хүртээжээ.

ГАВЬЯА ШАГНАЛ, СОНГУУЛТ АЖЛУУД

Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1945 оны 11 дүгээр сарын 6-ны өдрийн тогтоолоор Байлдааны гавьяаны улаан тугийн одон, Японы ялсны төлөө медаль, Улс, хувьсгалын 25 жилийн ойн медаль, "Бид ялав" медалиар шагнагдсан.

1951 онд "Алтан гадас" одон, 1967 онд Байлдааны гавьяаны одон, 1970 онд Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонг тус тус хүртээсэн.

Намын товчооны гишүүн, суман, дивизион, хорооны намын үүрийн дарга, намын товчооны дарга, дивизийн намын комиссын гишүүн, Ардын цэргийн намын төв комиссын гишүүн, Ардын цэргийн намын 9, 10, 11, 13 дугаар бага хуралд төлөөлөгчөөр сонгогдож, уг хурлуудын үйл ажиллагаанд идэвхтэй оролцжээ.

Тэрээр 1952 оноос Армийн намын бага хурлын гишүүн, Улс төрийн газрын товчооны гишүүн, Монгол Ардын Хувьсгалт нам (тухайн үеийн нэрээр)-ын Төв хорооны гишүүн, Ардын Их Хурлын депутат, тэргүүлэгч гишүүнээр сонгогдож, тасралтгүй 10 гаруй жил ажилласан.

ОРОН НУТАГТ АЖИЛЛАСАН ОН ЖИЛҮҮД

Ж.Цэнд-Аюуш 1960-1962 онд Архангай аймгийн нэгдүгээр нарийн бичгийн даргаар ажилласан. Энэ хугацаандаа тус аймагт Залуучуудын чуулга уулзалтыг анх удаа зохион



байгуулан намын анхан шатны байгууллагуудыг бэхжүүлэх, улс орон даяар явагдсан соёлын довтолгооны ажлыг эрчимжүүлэх, иргэдийг бичиг үсэгтэй болгох, өрх бүрд хэвлэл захиалуулах, төв суурин газрын өрхүүдийг шугамын радиотой болгох хөдөлгөөнийг өрнүүлэн нам, эвлэл, үйлдвэрчин, эмэгтэйчүүдийн байгууллагын албан тушаалтнуудыг дээрх ажилд идэвхтэй татаж оролцуулсан.

ХУВЬСГАЛТ ТЭМЦЛИЙН АХМАД ЗҮТГЭЛТНИЙ ХОРООНД АЖИЛЛАСАН НЬ

Монгол Ардын Хувьсгалт нам (тухайн үеийн нэрээр)-ын Төв хорооны Улс төрийн товчооны 1969 оны 13 дугаар тогтоолоор Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтний хороог байгуулагдах үед уг байгууллагын бүрэлдэхүүнд орж анхны даргаар нь томилогдон ажилласан. Ж.Цэнд-Аюуш дарга Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтний хороо гэдэг байгууллагыг улсын хэмжээнд байгуулахыг санаачлан хөөцөлдсөнөөр Төв хорооны тогтоол гаргуулж, холбогдох дүрэм, журмыг батлуулан мөрдөж эхлүүлсэн нь одоогийн Монголын ахмадын байгууллагын хөгжлийн эх үүсвэр болжээ. Ж.Цэнд-Аюуш энэ байгууллагад 1969-1971 онд анхны даргаар нь сонгогдон ажиллаж байсан юм.

ХОШУУЧ ГЕНЕРАЛ Ж.ЦЭНД-АЮУШИЙН САНААЧЛАН ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛУУД

Ардын цэргийн Улс төрийн газрыг хамтын удирдлагын зарчимд шилжүүлж Улс төрийн газрын товчоог байгуулсан.

Улс төрийн газарт Соёл гэгээрлийн хэлтсийг шинээр байгуулан цэргийн анги бүрд клуб, номын сан, кино, радио цэгийг бий болгож, "Дайчин алдрын танхим"-уудыг байгуулсан.

Монгол цэргийн музей байгуулах, Ардын Армийн дайчдын дурсгалын хөшөө босгох болон цэргийн түүх судлалын эхийг тавьсан.

Салбарын захирагчийн улс төрийн орлогчийн орон тоог 1964 оноос сэргээж, салбарт соёл хүмүүжлийн ажлыг сайжруулахад түлхүү анхаарч ажилласан.

Салбарын Сүхбаатарын тасалгаа бүрийг баян хуур хөгжимтэй болгосноор армийн хэмжээнд баян хуурчдын түр курсийг байгуулж хөгжимчдийг бэлтгэсэн.

Армийн бодлого, зорилт, үйл ажиллагааг болон зэвсэг, техникийг ард түмний дунд сурталчлах ажлыг санаачлан хэрэгжүүлсэн ба жилд 1-2 аймагт сурталчлах ажлыг хэрэгжүүлсэн. Энэхүү ажлыг Архангай аймаг ажилласан.

Улс орон даяар өрнөсөн соёлын довтолгооны ажлыг идэвхтэй санаачлан хэрэгжүүлснээр Ардын хувьсгалын 40 жилийн ойг угтсан хоёр жилийн ажлыг улсын хэмжээнд дүгнэхэд өөрийнх нь ажиллаж байсан Архангай аймаг тэргүүн байр эзэлж байсан.

Арми дотор өрнөж байсан социалист хөдөлмөрийн хөдөлгөөн, тасаг, тоотын бүрэлдэхүүн бие биеэ орлох мөн хос мэргэжил эзэмших, анхны сумаар байг сөнөөх зэрэг бүтээлч ажил, санаачилгуудыг дэмжин дэлгэрүүлсэн.

Барилгын анги, салбаруудыг бэхжүүлэн социалист уралдаан, өндөр зүтгэлийн аяныг зохион байгуулж "Дархан хотоо залуучууд Дархан хүн шиг бүтээгчээ" хөдөлгөөнийг өрнүүлэн ажилласан.

Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтний хороог улсын хэмжээнд санаачлан байгуулсан ба үйл ажиллагааг нь бэхжүүлсний зэрэгцээ "Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн" тэмдгийг бий болгож, холбогдох дээд байгууллагын тогтоол гаргуулсан.

Онц сурлагатан, онц буудагч, сайн нисгэгч, онц тасаг, тоот, экипаж, салаа, салбарын эгнээг өргөтгөх, тэдний туршлагыг нь дэлгэрүүлэн сурталчлах, шагнаж урамшуулахыг ажлынхаа гол зорилго болгон жил бүрийн цэргийн баяраар Монголын Хувьсгалт Залуучуудын Эвлэлийн Төв хорооны товчоонд армийн тэргүүний залуучуудыг хүлээн авч шагнадаг уламжлалыг тогтоож байсан.

Хошууч генерал Ж.Цэнд-Аюуш нь цэргийн улс төрийн бүх шатны байгууллагыг дамжин дэвшин ажилласан мэргэжлийн улс төрийн ажилтан хүн байсан юм. Түүний хэлсэн "Хүний дутагдлыг харахаас өмнө өөрийгөө шинжиж бай, өөрийгөө хөгжүүлсэн хүн өөдөлнө, үнэнч шударгын үнэ цэн хязгааргүй, дэг журамтай хүн дэвшин дээшилнэ, сайны жишээнээс шамдан суралцвал зохин", "Амар хялбар ажил гэж байдаггүй, хүнд сэтгэлийн тэнхээ хатуужил, саруул ухаан хэрэгтэй. Сэтгэл зүтгэлтэй хүний үйлс бүтнэ" зэрэг үгс өнөөдөр ч өндөр ач холбогдолтой байгааг онцлон тэмдэглэе.

Бэлтгэл хурандаа Б.ЖУВАА

МОНГОЛ ЦЭРГИЙН МУЗЕЙН САН ХӨМРӨГӨӨС

МОНГОЛ УЛСЫН АНХДАГЧ ГЕНЕРАЛУУДЫН СОЁЛЫН ӨВИЙН ДЭЭЖИС

Монгол Улсад генерал цол бий болсны 76 жилийн ойг тохиолдуулан эрхэм хүндэт анхны генералуудын эдэлж хэрэглэж байсан соёлын өвийн дээжсээс уншигч олондоо цувралаар толилуулахын зэрэгцээ энэ удаагийн дугаараар залуу жанжин Ж.Лхагвасүрэнгийн эд зүйлсээс онцлон хүргэж байна.


1944 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр генерал цол хүртсэн анхны 11 генералын түүхэнд холбогдох эд өлгийн зүйлс Монгол цэргийн музейн сан хөмрөгт цөөнгүй бий.




Тухайлбал, хурандаа генерал Ж.Лхагвасүрэн, хошууч генерал С.Равдан, Г.Осор, С.Балдан, Б.Дорж, Г.Рэндоо, Д.Дамдинхүү нарын ёслолын болон дурсгалын генерал сэлэм, кинжаал, дурсгалын буу, дүрэмт хувцас, одон, медаль, элчин сайдын үнэмлэх, бэлэг, дурсгалын зүйлс зэрэг нь музейн үзэмрт дэглэгдэж олон түмний мэлмийг мялааж байдаг билээ.

Генералын ёслолын сэлмийг 1944 онд ЗХУ-д Златоустын зэвсгийн үйлдвэрт захиалгаар хийлгэсэн бөгөөд уг сэлмийн эх зургийг Төрийн шагналт зураач Д.Чойдог агсан зохиожээ. Генерал болгонд бус эрхэм нэр хүндтэй цөөн тооны генералд энэхүү эрдэнийн шигтгээтэй ёслолын сэлмийг дурсгадаг байжээ. Энэ загварын сэлмийг анхны 11 генералаас дэслэгч генерал цол хүртсэн Ж.Лхагвасүрэн, Ю.Цэдэнбал нарт олгожээ.

1990 онд тус музейн сан хөмрөгт анх бүртгэж авсан түүхтэй. Уг сэлэм нь 5,83 сорьцтой, нийт 14 ширхэг алтадмал чимэг, хоёр алтадмал гархи, таван ширхэг рубин шигтгээтэй. Урт нь 96 см, өргөн 3 см, зэвэрдэггүй гангаар хийсэн. Бариулын үзүүр ба уг нь алтадмал чимэгтэй,



түүний нэг талд нь 1940 оны сүлд, рубин шигтгээ бүхий таван хошуутай. Сэлмийн бариулаас урагш үнхэлбэрийн хэсэгт "МАХЦ-ийн генерал" гэж алтадмал дэвсгэр дээр бичжээ. Сэлмийн хуйг алтан шармал алхан хээ бүхий гурван ширхэг бүслүүрээр чимж, хоёр бүслүүрээс нь оосор зүүх зориулалттай хоёр алтадмал гархийг тус тус бэхэлжээ. Гархины диаметр хоёр сантиметр. Уг сэлмийн бариулын үзүүрийг алтадмал эвэр хээгээр чимж, хуйны нэг талд хаан бугуйвч, өлзий болон ромбон хээг тус бүр нэг, эвэр угалз таван ширхгийг мөн алтадмал металлээр цоолборлон чимсэн байна. Залуу жанжин Ж.Лхагвасүрэнд дурсгасан ёслолын сэлэм нь түүний үр хүүхдүүдэд бахархалт өв нь болж хадгалагдаж байгаа билээ.



27 насандаа дайныг удирдаж, 32 насандаа хошууч генерал цолыг алгасаж дэслэгч генерал цол, жанжны алдрыг хүртсэн БНМАУ-ын баатар, хурандаа генерал Ж.Лхагвасүрэнгийн эд зүйлсийн дээжсээс товч толилуулъя.

Монгол Улсын түүхэнд тохиолдсон хоёр томоохон дайнд цэрэг дайчдаа удирдан орж, ялалт байгуулсан хурандаа генерал Ж.Лхагвасүрэн цэргийн эрдэмд боловсорсон авьяаслаг жанжин байсныг түүхэн үйл явдлууд тодхон гэрчилдэг.



1956 оны үед өмсөж байсан дүрэмт хувцас

БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1944 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 22 дугаар хурлын тогтоолоор Монгол ардын хувьсгалт цэргийн дарга нарыг нийтэд нь офицер хэмээн нэрлэхээр болж, цэргийн цолыг шинэчилжээ. Үүгээр маршал, генералуудын хувцсанд бүтэн, хагас эполет тэмдэг, офицеруудын шинель, цамцны мөрөнд погон (мөрдэс) зүүхээр болж, түүнд алт болон мөнгөн өнгийн давхар хошуутай, дан хагас үндэсний өлзий тэмдэгтэй болсон. Цэл залуухан жанжин, дэслэгч генералын дүрэмт хувцсаа өмссөн гэрэл зургийг хэн бүхэн тодоор санах буй заа. Тэрээр Сүхбаатарын одонгоор гурван удаа, Байлдааны гавьяаны улаан тугийн одонгоор дөрвөн удаа, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон, Байлдааны гавьяаны одонгоор гурав, "Алтан гадас" одонгоор хоёр удаа болон бусад ойн медалиар шагнагдсан бөгөөд БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1989 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн зарлигаар БНМАУ-ын баатар цол нэхэн олгосон юм. Мөн ЗХУ-ын Суворовын II зэргийн одон, Улаан таван хошуу одон, Октябрийн хувьсгалын одонгоор шагнагджээ. Жанжин Ж.Лхагвасүрэнг 1939 оны 9 дүгээр сард Цэргийн яамны сайд, Бүх цэргийн жанжны орлогчоор тохоон томилсон байна. Халхын голын байлдаанд үүргээ онц сайн гүйцэтгэсэн учир Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн зарлигаар Байлдааны гавьяаны улаан тугийн одонгоор шагнуулсан нь түүний авсан анхны одон байв.

1945 оны Чөлөөлөх дайнд Ж.Лхагвасүрэн Зөвлөлт-Монголын морьт механикжуулсан бүлгийн командлагч И.А.Плиевийн орлогчоор ажиллаж Монголын цэргийг командалсан юм. Цаг агаарын хүндхэн өдрүүдэд Хянганы нурууг дайсны эсэргүүцэл, галын дор давах зэрэг нэн хүнд нөхцөлд цэргийн хүнд хүчир ажиллагааг Ж.Лхагвасүрэн бусад дайчин нөхдийн хамт чадварлаг шуурхай зохион байгуулж, тавигдсан байлдааны үүргийг эрэлхгээр биелүүлж чадсан билээ. Ийм учраас фронт командлагч Р.Я.Малиновский "Цэргийг чадамгай удирдсан учир ЗСБНХУ-ын Дээд зөвлөлийн тэргүүлэгчид дэслэгч генерал Ж.Лхагвасүрэнг Суворовын II зэргийн одонгоор шагнасан"-ыг албан ёсоор мэдэгджээ. Монгол Улсын түүхэнд Зөвлөлтийн армийн хамгийн дээд одон Суворовын одонгоор шагнагдсан хоёр хүн байдгийн нэг нь залуу жанжин билээ. Х.Чойбалсанг Суворовын I, жанжин Ж.Лхагвасүрэнг II зэргийн одонгоор шагнасан юм.



Ж.Лхагвасүрэн ЗХУ-ын цэргийн дээд курс, улмаар Фрунзийн нэрэмжит цэргийн академийг онцдүнтэй төгссөн. 1939, 1945 оны дайнд фронт командалж, Зөвлөлтийн олон арван цэргийн зүтгэлтний баялаг туршлагаас сурч, ялангуяа маршал Г.К.Жуковтай их ойр хамтран ажилласан тэр үеэс жанжны мэдлэг, зохион байгуулах авьяас чадвар



нь тодорсон гэж цэргийн зүтгэлтнүүд үздэг юм. Буудах чадвараараа офицер, дайчдын бишрэх сэтгэлийг аргагүй төрүүлдэг байсан сан зэрэг олон сайхан дурдатгалууд байдаг. Энэ ч утгаараа түүнд АНУ, Болгар зэрэг орны томоохон төлөөлөгчдийн бэлэглэсэн буу цөөнгүй бий. Түүний нэг нь Цэргийн музейн сан хөмрөгт байдаг 9 мм-ийн автомат гар буу юм.

Тус буу нь АНУ-д 1966 онд үйлдвэрлэгдсэн, тусгай хайрцагтай, мөрлөгч бариул нь тэнийдэг, нэгээр болон автоматаар галлах боломжтой автомат пистолет юм.

Маршал Х.Чойбалсантай ойр шадар ажиллаж, түүний итгэлийг хүлээсэн цэргийн эрдэмд боловсорсон жанжин байсны хувьд түүнд олон том ажил даалгаж,



Герман улсад үйлдвэрлэсэн, агаарын даралт хэмжигч барометр, дулаан хэмжигчтэй, арьсан гэртэй ширээний цаг.

зуд, түймэр, үер болсон ч томилоод явуулдаг баяжээ. Тэрээр аливаа ажлыг зохион байгуулахдаа их сайн байсны жишээг өгүүлсэн нэгэн зүйл нь энэхүү дурсгалын цаг юм.

“Улсын 25 жилийн ойн баярын комисст сайн ажилласан нөхөр Лхагвасүрэн дүүгээр дурсгал болговой. Ерөнхий сайд Чойбалсан” хэмээн бичсэн дурсгалын үгтэй.



БХЯ-ны сайдаар ажиллаж байхдаа болон амьдралынхаа сүүлийн жилүүдэд зүүж байсан нүдний шил

БНМАУ-ын баатар, хурандаа генерал, залуу жанжин Ж.Лхагвасүрэнгийн түүхэнд холбогдох 50 гаруй эд зүйл тус музейн сан хөмрөгт хадгалагдаж, улсын соёлын өвд бүртгэгдэн олон түмэнд сурталчлагдаж байна.

Монгол цэргийн музейн мэргэжлийн албаны дарга, эрдэм шинжилгээний ажилтан А.ГАНГАНЧИМЭГ

ХУРАНДАА ГЕНЕРАЛ Ж.ЛХАГВАСҮРЭНГИЙН ГЭГЭЭН ДУРСГАЛД

ӨВГӨН ГЕНЕРАЛТАЙ УУЛЗСАН СҮҮЛИЙН СУРВАЛЖИЛГА

(Түрүүч нь VI нүүрт)

Хамгийн сүүлд маршал Г.К.Жуковийг эмнэлэгт хэвтэж байхад нь уулзахаар очихдоо 20 минутын зөвшөөрөлтэй байсан боловч хуучин дайчин нөхөд хууч хөөрөлдсөөр бүтэн цаг болсон юм даг. Салахдаа тэр үед нэрд гарсан "Бодол дурдатгал" ("Воспоминание и Размышление") хэмээх дурсамжийн номоо гарын үсэг зурж бэлэглэснийг бидэнд үзүүлж бахархан ярьж билээ.

Ингээд тэрхүү нэвтрүүлгийн ярилцлага сайхан болсон юм. 12 дугаар сарын 5-ны өдөр бид нэвтрүүлгээ эфирт шилжүүлж билээ. Нэвтрүүлэг телевизээр гарах өдөр "Сонгино"-д байрлах хурандаа Төмөр захирагчтай артиллерийн хороон дээр зураг аваад оройхон ирэхэд телевизийн дарга М.Чойжил дуудаж байна гэлээ. Чойжил дарга та нар үзэл суртлын талаар алдаатай

нэвтрүүлэг хийсэн байна. Намын Төв хорооны үзэл суртлын хэлтсээс хүмүүс ирж үзээд нэвтрүүлгийг хаасан. Лхагвасүрэн маршал Жуковийн хэмжээнд өөрийгөө тавьж магтсан, өөрийнхөө гаргасан амжилтыг хэт дөвийлгөж ярьсан гэх мэтээр буруутгасан нь гаргахгүй шалтгаан нь болжээ. Ингээд сэтгэл дундуур редакцад орж ирвэл Лхагвасүрэн генерал ярьж байв. Генерал нэвтрүүлэг яагаад гарсангүй вэ гэж асуувал бантаж үнэнийг хэлж зүрхэлсэнгүй, харин техникийн шаардлага хангаагүй учир хаасан гэж даргын хэлснийг нь хэлсэн юм. Тэгэхэд Лхагвасүрэн генерал "Чи ажлаа тараад завтай бол хүрээд ир" гээд гэрийнхээ хаягийг зааж өглөө. Тэднийх хуучнаар Хүнсний 20 дугаар дэлгүүрийн зүүн талын гурван давхар байранд байсан юм. Хаалгыг нь тогшин орвол генерал маань онгорхой хаалганы завсраар хуучны гоёмсог даавуун бүрхүүлтэй ширээний чийдэнгийн дэргэд сонин

уншиж сууснаа намайг харж угтан босож, өөрийн хажууд суухыг урилаа. Тэгээд гэр бүлийн хүнээ дуудаж "Дашцэдэн минь, энэ хүүхэд ажил дээрээсээ яваа юм. Хоол, цай дөхүүлж өгөөрэй" гэв. Өвгөн генерал ам нээж юунаас болоод нэвтрүүлэг хаагдсан тухайд, миний зүрхний угт байгаа сэдвийг хатгав. Нөгөө улиг болсон юмаа ярьж эхэлбэл генерал "Хүү минь чамд буруу юу байх вэ дээ, би ерөнхийд нь мэдэж байна. Сүүлийн үед надтай холбоотой, миний тухай сонин хэвлэл, радио, телевизээр нэвтрүүлэхийг хориглоод байгаа юм. Энэ нь цаашдаа их учиртай гээд санаа алдангаа миний тухай Намын төв хороонд таагүй мэдээ, мэдээлэл дамжуулдаг том хүмүүс байдаг юм. За яах вэ дээ цаг нь болж дээ" гэсэн юм. Миний хувьд энэ үед хоол, цай хоолойгоор давах нь битгий хэл, хамаг бие халуун оргин балмагдан сууж билээ. Дараа нь сонсох нь ээ, нэвтрүүлгийг хасаж маршал Г.К.Жуковийн гурван


бүлэг баримтат киног гаргаж, харин фондоод байсан генералын дурсамж яриатай нэвтрүүлгийн бичлэг ор мөргүй алга болсонд би харамсаж явдаг юм.

Харин Лхагвасүрэн генералыг нас барахаас нь өмнө амжиж дурсамжийг нь бичүүлж эмхэтгэснээр сэтгүүлч Д.Дамдиндорж "Сэтгэлд шингэсэн он жилүүд" номыг амьдад нь дуусгаж чадаагүй боловч дараа нь хэвлүүлсэн юм. Хожим ахынхаа номд Жамъянгийн Зундуй гуай дурсгалын үг бичиж надад дурсгаж билээ. Зундуй ах Халхын голын байлдаанд 6 дугаар морьт дивизийн 17 дугаар морьт хорооны салааны захирагч байсан юм. Тэрхүү эрхэм маань дайсантай онц гарамгай байлдаж Байлдааны гавьяаны улаан тугийн одонгоор шагнагдсан "эх оронч" Ж.Зундуй хэмээн алдаршсан хүн байлаа. Зундуй ах миний ээж Д.Базарын садан төрлийн хүн Лхасранжав эгчтэй амьдарч байсан юм. Ээж маань биднийг Зундуй

ахынхантай танилцуулсан ба бид ойр дотно байж сар шинээр очиж золгодог байлаа. Зарим дүү маань хотод сургуульд байхдаа ч тэднийд амьдардаг байлаа. Зундуй ах Хэнтийд очихоороо манайхаар их очдог байсан. Тэдний хүүхдүүд Ууганаа, Дуламсүрэн, Сэргэлэн, Баясаа, Жавхаа бид нар ахан дүүс бололцсон юм. Залуу жанжин Ж.Лхагвасүрэнгийн хүү Л.Лхагваа нь манай армийн нэртэй хурандаа бөгөөд Иргэний агаарын тээврийг удирдах газрын дарга байхад нь би бээр сурвалжилга хийн танилцаж байлаа.

Харин охин Ж.Лхагвадулам нь Монголын радиод олон жил үр бүтээлтэй ажиллаж байсан нэртэй сэтгүүлч бөгөөд бид мэргэжил нэгтэй болохоор бие биеэ ихэд хүндэтгэж явдаг юм. Өнгөрсөн цаг хугацааны их урсгалын толинд энэхүү дурсамж тодоос тод хонгошин үлдсэн нь энэ билээ.

Найруулагч С.БОЛД



Дугаарын зочин

Х.Ундрах: ӨӨРИЙГӨӨ МОНГОЛ ДАХЬ 2РАС-ЫН ХАМААТАН ГЭСНИЙ УЧИР ...

“Give me justice”, “Рашаантын 18” зэрэг дуугаараа олонд танигдсан Расгар буюу Х.УНДРАХТАЙ ярилцлаа.



Юуны өмнө аав болсонд нь баяр хүргэе. Аав болсон эхний саруудыг завгүй өнгөрөөсөн байх ...

-Баярлалаа. Гэр бүлдээ урьдынхаасаа илүү их цаг зарцуулах болсон. Бас аав хүн ямар байх ёстой талаар суралцаад л явж байна даа.

“So many tears” дуу нийтэд хүрээд удаагүй. Тус уран бүтээлээрээ дамжуулан ямар нэгэн байдлаар нэгдэж нийгмийг хамтдаа өөрчилцгөө гэж уриалсан нь бидэнд нэгийг бодогдуулсан шүү ...

-Бүхий л уран бүтээлээрээ аливаа нэг эмзэг сэдвийг хөндөхийг хичээдэг. “So many tears” дуугаа бараг дөрвөн сарын өмнө бэлэн болгочихсон байлаа. Анх продюсер маань надад ийм дуу хийе гэж санал тавьсан юм. Дүржүүлэх тохиромжтой цагийг хүлээгээд саяхан л ажил хэрэг болголоо. Хүүхдийн эрхийг хамгаалдаг олон байгууллагатай хамтарч ажилласныг энэ клипнээс анзаарсан байх. Тохироо бүрдэнэ гэдэг шиг гар нийлж амжилттай ажилласандаа баяртай байна. Клип хийхэд дэмжлэг үзүүлсэн байгууллагуудтай нийлж тодорхой хэмжээний хандив бүрдүүлээд “Хүүхдийн тусламжийн 108 төв”-д дуудлагын машин авч өгөхөөр ажиллаж байгаа. Цаашид ч олон ажил хийх төлөвлөгөө бий.

Ихэнх тохиолдолд үгээ бичиж дуусгааг түүндээ ая хийлгэдэг. Харин өөрийн чинь хувьд эсрэг зарчмаар ажилладаг гэсэн. Энэ нь юугаараа онцлог, давуу талтай байдаг вэ?

-Хамгийн түрүүнд санаагаа олох нь чухал. Бид

санаагаа ярилцаж дараа нь ая хийдэг. Ингээд би үг бичиж ажилдаа орно. Аяны хэмнэлээс санаа, үг урган гарах нь олонтоо. Аль эсхүл мартагдсан, өмнө нь төлөвлөж байсан зүйлс ч сэргэдэг. Гэхдээ дандаа ийм арга барилаар ажилладаггүй. Заримдаа сэдвээ бодож байгаад эхний хэдэн мөртийг нь буулгачихдаг. Тэгээд үгэндээ тохирсон ая оллоо хүлээнэ.

“Give me justice” өөрийг тань олонд илүүтэй таниулж өгсөн уран бүтээл. Харин тэрхүү уран бүтээл төрөн гарахаас өмнөх Расгар-ийн талаар хүмүүс төдийлөн мэддэггүй ...

-Багаасаа “Hip Hop”-д сонирхолтой, үнэнч байсан. Гурван жилийн өмнөөс уран бүтээлээ тууштай хийж эхэлсэн. Ямартаа ч 30 гаруй дуутай. Арваад клип бий.

Багагүй тоо сонсогдож байна. Цомог бий юу?

-Аудио хэлбэрээр гаргасан нэг цомогтой.

Хөвсгөл аймгийн залуусаас бүрдсэн “Eternal” хамтлагаас хойш олон нийтэд танигдаж, тренд болж чадсан уран бүтээлч гэвэл яахын аргагүй өөрийг тань нэрлэх байх ...

-Би Хөвсгөл аймгийн Мөрөн хотын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийг төгссөн. Сонирхуулахад, “Rap Dem-bee” шиг үйл ажиллагаа Мөрөн хотод ч бас тогтмол зохиогддог байсан. Би ч түүнд нь их идэвхтэй хамрагддаг байлаа. Сурагч байхдаа хэд хэдэн дуугаа бичүүлж, хамтарсан тоглолтоо ч хийгээд амжсан. Багадаа бүр монгол бүжиг бүжиглэдэг байсан гэвэл итгэх хүн цөөн байх. Юм юмыг л оролддог хүүхэд байсан даа. Тэгээд анх 14 настайгаасаа

дуулах сонирхолтой болсон гэх үү дээ. Намайг эрчимтэй хэмнэлд оруулсан уран бүтээл гэвэл 2016 онд “Unbox” студид бичүүлсэн “Deadpool” нэртэй дуу.

“Give me justice”-ийн үгийг Хөвсгөл далайн эрэг дээр бичсэн гэсэн. Тэнд онгод хөглөгддөг юм уу?

-Бүхэлд нь бичээгүй. Зарим нь өмнө нь бичигдсэн байсан юм. Далайн эрэг дээр байхад шүлэг бичих таатай нөхцөл бүрддэг гэж ойлгож болно. Усны чимээ маш сайхан. Анхаарал маш сайн төвлөрдөг. Манайх Хөвсгөл аймгийн Хатгал суманд амралтын газар ажиллуулдаг. Би заримдаа очиж чадахаараа л тусалдаг юм. Ер нь ажил ихтэй өнждөг. Оройдоо зав гарвал далайн эрэг дээр очиж үгээ бичихийг л бодно. Гэхдээ тэр бүр очоод байж чаддаггүй.

Манайхан уламжлалт зүйлсийг л их дэмжиж хүлээж авдаг. Харин энэ замыг сонгоход гэр бүлийнхэн тань ямар хандлагатай байсан бэ?

-Би элсэлтийн шалгалтаа их өндөр оноо авсан. Багаасаа математикийн хичээлд сонирхолтой бас дажгүй сурлагатай байсан. Авсан оноогоороо ШУТИС-ийн архитектурын ангид орох боломжтой боллоо. Манай аймагт тийм хуваарь ганц, хоёрхон ирдэг учраас хөөрөөд л орчихсон. Дэндүү яарсан шийдвэр гаргасан гэдгээ хожим ухаарсан даа. Үнэндээ Соёл урлагийн их сургуулийн жүжигчний ангид орно гэж боддог байсан юм. Эхэндээ архитектураар сураад байж болмоор санагдсан учраас нэг их санаа зовоогүй. Гэвч цаг хугацаа надад дэмий зүйл байж гэдгийг ойлгуулсан. Хүн ер нь сонирхолгүй зүйлдээ сэтгэл гаргадаггүй. Ялангуяа албадаж шахсан зүйлд. Гэхдээ аав, ээжийнхээ надад үзүүлсэн итгэлийг ингээд ор хоосон зүйл болгочихмооргүй санагддаг байлаа. Их эмээж байсан ч энэ талаар ярилцаад хоёр сонголт байгаа талаар хэлсэн. Эндээ уран бүтээлээ хийнэ эсхүл гадагшаа явмаар байна гэж. Тэгээд л Солонгос улсад очиж нэг жил амьдарсан. Харин ирээд рэлээ эрчимтэй үргэлжлүүлсэн. Энэ үед ч миний гэр бүл намайг дэмжжээр л байсан. Ер нь ч анхнаасаа л тийм байсан шүү.

“Give me justice” дуу олны анхааралд өртөж, шуугиан нь намжаагүй байхтай зэрэгцээд “Рашаантын 18” гэх уран бүтээлээ гаргасан. Тус уран бүтээлээр юуг илэрхийлэхийг зорьсон бэ?

-Залуусыг зорьж, хүсэж байгаа зүйлийнхээ төлөө шантралгүй хөдөлмөрлөөсэй гэж хүссэн. Бас өөр хэд хэдэн дэд санааг өгүүлдэг. Жишээлбэл, “Хүн тарган турьхан, өндөр нам байх нь чухал биш гэдгийг ойлгох хэрэгтэй. Зүгээр суухаар,

хамгийн гол нь түүний сэтгэл, чамд итгэх итгэл” гэдэг хэсэг. Хүнийг гаднах үзэмжээр нь дүгнэхгүй гэдэг мөртлөө яг цаг нь тулахаар шал худал байдаг. Тийм зүйлтэй олон таарч байсан.

“Give me justice” дууг гаргасныхаа дараахан Хууль зүйн дэд сайд асан, хуульч Б.Энхбаярын хамт “Уухай” подкастанд оролцсон байсан нь нэлээд анхаарал татах шиг болсон ...

-“Give me justice” дууг сонсоод намайг Б.Энхбаяр ахтай хамт урьсан юм билээ. “Шударга ёс” хэмээх подкаст байсан. Бид шударга ёс, залуусын идэвх, оролцооны талаар ярилцсан. Бас “Give me justice” дууныхаа талаар дэлгэрэнгүй тайлбар хийсэн юм.

Өөрийгөө яагаад 2Рас-ын Монгол дахь хамаатан гэж тодорхойлсон бэ? Ямар нэгэн сонирхолтой түүх өгүүлэх байх ...

-2Рас-ыг анх сонсоход их хүчтэй мэдрэмж төрж, чих нээгдэж билээ. Өмнө нь Eminem-ийн дууг их сонсдог байсан. Түүнээс хойш 2Рас-ын үзэл баримтлалыг нь судалж үзээд бүр дуртай болсон. Тууштай, зоригтой зан чанар нь таалагддаг. Тавхан жилийн хугацаанд 500 хол давсан дуу гаргасан байдаг шүү. Өөр нэг сонирхолтой зүйл гэвэл, 2Рас 1996 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр Лас Вегаст буудуулсан гэдэг. Би яг тэр өдөр нь төрсөн. 2Рас шархаа даалгүй хэд хоногийн нас барсан гэдгийг нь би хожим уншиж мэдсэн л дээ. Өөртөө Расгар гэдэг нэр өгөхдөө 2Рас-ын Рас-ыг авч Rap гэдэг үгтэй хоршуулсан гэх юм уу даа.

“Give me justice” дууны клип дээр хамт алхдаг залуу танай дүү гэдгийг мэдлээ. Хүмүүс хажууд нь алхаж байгаа залууг дуулах байх гэж харуулдсаар байгаад дуусгалаа гэж хошигносон байна лээ ...

-Дүүтэйгээ ямар нэгэн зүйлийг хамтдаа хийнэ гэсэн санааг л илэрхийлсэн. Анзаарвал дуу эхлэх цагаас дуусах хүртэл хамт байдаг шүү дээ. Дуулах юм байх гэж их хүлээлээ, яасан хийцгүй залуу вэ гэсэн хөгжилтэй сэтгэгдлүүдийг их уншсан. Дүү маань ч уншаад над руу нэг бүлтийж харсан шүү. /Инээв/

Сүүлийн үеийн уран бүтээлүүд тань нийгмийн эмзэг сэдвүүдийг хөндөж байгаа. Ингэж ажиллахад унаган зан тань нөлөөлдөг тал бий юу?

-Монголчууд бэлэн нулимстай гэж ярьдаг. Би яг тийм биш ч гэлээ их өрөвч, эмзэг. Багын тийм хүүхэд байсныг найз нөхөд, гэр бүлийнхэн маань сайн мэднэ. Гадаа гуйлга гуйгаад сууж буй хөгшид, хүүхэд, сав, лааз, шил түүж амьдралаа залуулдаг хүмүүсийг хараад их хэцүү

санагддаг. Өр өмрөөд байдаг юм. Тэд энэ нийгэмд сайн сайхан амьдарч, бүлээн хөнжилд, бүтэн амьртой унтах ёстой. Тийм эрхтэй.

Дууны шүлгийн мөрүүд утга санааны хувьд зохилдлоготой, их оновчтой санагддаг. Яруу найраг сонирхдог уу?

-Р.Чойномын шүлгийг их шимтэн уншдаг. 2Рас болон Р.Чойномын зураг ханан дээр минь өлгөөстэй байдаг.

Олонд танигдаад уран бүтээлээ тодорхой хэмжээнд үнэлүүлээд ирэхээр хэнээс ч хамаагүй захиалга ороод ирдэг гэсэн. Энэ үнэн үү?

-20, 30 саяыг өгье, ийм утга, агуулгатай дуу хийгээд өг гэдэг юм билээ. Би ч яах вэ, дорвитой хариу өгөлгүй өдийг хүрсэн. Их мөнгө амласан байлаа ч надад чухал биш. Үзэл санааны хувьд зөрүүтэй зүйлүүд байсан учраас татгалзаар ирсэн. Ер нь худалдагдах дургүй. Хэрвээ худалдагдвал улс төрийн сонгуулийн үеэр өөрийн үзэл бодлоосоо урвах болно гэж эмээдэг.

Залуусын улс төрийн идэвх, оролцооны талаар ямар бодолтой байдаг вэ?

-Хуульч Б.Энхбаяр шиг хүн олон байгаасай гэж боддог. Одоогийн нөхцөл байдалд, залуусын улс төрийн оролцооны талаар ойлгож, хүлээж авахад нэг их ном уншаад, гэгээрээд байх албагүй мэт санагдсан. Бүх зүйл тодорхой. Би залуусын идэвх, оролцоог сулхан л гэж хэлнэ. Ер нь улс төрийн сонгуулийн үеэр л илт ажиглагддаг. Ядаж л очоод ирцээ бүртгүүлчихдэггүй.

Цаашид ч дуугаараа ямар нэгэн сэдвийг хөндсөөр байх уу?

-Саяхан нэгэн сэтгүүлч залуу насны минь өвчин илаарьших үед би ч бас эндээс явсан байх болно гэж бичсэн байсан. Миний хэлэх гэснийг их оновчтой гаргасан байна лээ. Би нэгэнт эхлүүлсэн, үүнд бас их зүйл золиосолсон болохоор зогсохгүй байх аа.

Тамхинаас татгалзана гэж хэлснийг тань залуус их эергээр хүлээж авсан шүү. Гэр бүл төлөвлөж байсан учраас тэгж хэлсэн үү?

-Анхандаа миний харагдах, үзэгчдэд хүрэх байдал үргэлж тамхитай хамт дүрслэгддэг байсан. Миний хэв маяг, бусдаас ялгарах байдал гэж бодож байсан л даа. Гэхдээ нийгэмд, бусдад их муу үлгэр дуурайл үзүүлж байгаага ойлгосон.

Цаашид ямар зүйлийг төлөвлөж байна вэ?

-“Ухал дайрсан” коронавирусын дэгдэлт намжавал төлөвлөсөн зарим ажлаа хийж эхэлмээр байна. Ямартаа ч анхны тоглолтоо хийнэ гэсэн бодол бий.

Ярилцсанд баярлалаа. Танд амжилт хусье. Дэслэгч Ц.ЭНХ-ОРГИЛ

ЖАРГАЛЫН НУЛИМС

Олон бодлын гүн дэх сэтгэлийн хар үүлсээ жаргах наранд хэлж сэтгэлээ хөнгөлж сууна, би. Аавын тухай бодоод нулимс унагах нүгэлт үрийн үйлийн үрийг нүцгэн ирээд, нүцгэн буцдаг энэ орчлонд өөрөөс минь өөр мэдэх хүнгүй болохоор чимээ аниргүй гуниглаж суухыг илүүд үзэнэ, би. Аавын тухай дуу, ном, зохиолд эцэг хүнийг энгүй баатар, ухаан төгс, бахархал байсан хэмээн дурсдаг нь арга ч үгүй дээ. Хүн гэдэг амьд байхад нь буяныг нь мэддэггүй мунхаг, харалган амьтан.

О.Дашбалбар агсны “Залуус дүү нартаа хүргэх шүлэг”-ийн “Одоо л жаргаана даа гээд иртэл Орчлонгийн тоглоом даанч хатуу” гэсэн хоёрхон мөрт их зүйлийг бодогдуулж билээ.

Миний эцэг Боржигон овогт Тойвгоогийн Отгонмөнх нь Тайж гаралтай тавилан заяаны учгаар гурван үрийн зулай үнэрлэсэн хөрслөг бор эр. Зэвсэгт хүчний 189 дүгээр ангид амьдралынхаа 20 жилийг зориулж яваа алтан соёмбоо тэргүүндээ залсан мөрдөстэй жолооч. Эрээн хувцсанд зүүсэн цолоор биеэ гоёж жавхаажсан, энгэртээ тэврэх үрсээрээ ирээдүйгээ тодорхойлсон, хоол цайных нь дээжийг тавьж, халуун байлгадаг халамжит ханиараа хувь заяагаа хөглөсөн энэ эгэл хүн бусдаас онцгойрох зүйлгүй ч миний хувьд баатар, бахархал минь билээ. Тариан түрүү боловсрох тусмаа бөхийдөг гэдэг шиг миний аав хонины номхон морь шиг буурьтай, тулхтай, хангайн уул шигээ ханагар сайхан эр.

Энэ дэлхийд нар ганц, хүнд аав ганц байдаг.

Эгэл даруу аав минь та намайг 25 нас хүртэл хатуухан үг хэлж, чанга гараар хүмүүжүүлээгүй ч харцнаас чинь ухаарч, хааяа хэлэх хэдхэн үгэнд чинь нууцхан нулимс унагаж суудаг шүү, хүү чинь.

Миний аав 10 хүүтэй айлын аагтай шаргал цайг аяга аягаар нь оочилж өссөн цөлх эр. Ухааны дээд гэж эцгээ би магтахгүй, улс эв орондоо дурсагдах алдартай гэж аавыгаа би шагшихгүй ч хувь заяаны эрхээр ирэх зовлонг хүүгээ ухаарсны дараа үлдээгээрэй гэж хүү нь танаасаа гуйя. Өлгийтэй байхаас минь өдий хүртэл эцэг тэнгэр минь та амьдрал хэмээх уулын бэлд мацаж яваа энэ үед ч хажууд минь байгаа болохоор ар хөвчийг аяланхан жаргах ардын дууны эр хонгор аялгуу минь оргилд нь гарах тэр өдрийг хүртэл хүүгийнхээ дэргэд жаргаж хамт

байгаарай. Уяхан сэтгэлийн минь учиг болсон миний аав хүний орчлонд ухаант ээжтэй минь ханилаад хатуу үгээр хэлж байгаагүй болохоор аядуу зөөлөн харцанд чинь, ааш ялдам занд чинь уярч жаргалын нулимсыг нууцхан амталж явна даа.

Тарвагатайн нуруунд тогтож үлдсэн Тогоруун цэнхэр нулимс Нүд баясгаж хараа булаах Хангайн цэнхэр рашаан Хангайн уулсын ноён оргил Хан Маргаз уул Сарлаг үхрийн сор болсон Согоотын даваа Согоо буга нь бэлчих Агьтын баруун өвөлжөө нь Асаж дүрэлзэж явсан залуу насных нь дурсамж болсон миний эцгийн шилбүүрийн мөртэй нутаг.

“Дуулга” телестудийн зураглаач О.ТӨРТОГТОХ



СОЁМБО СОНИН

“Соёмбо” сонин 96 дахь жилдээ хэвлэгдэж байна.
Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА,
Д.НАЦАГДОРЖ

Эрхлэгч
Хурандаа
Батжаргалын
ОТГОНБАЯР

Эхийг “Соёмбо” сонин
реликвэд бэлтгэж,
“Соёмбо принтинг” хэвлэх
үйлдвэрт хэвлүүлэв.

*Зар, рекламгыг хямд нийтэлнэ.

*Зар, рекламны үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.

*Зохиогчийн үзэл болон сониний нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.

*Тус сонин мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон
Индекс 10018

И-мэйл хаяг:
Mil_newssoyombo@yahoo.com
Утас: 70001029